

Сайнмэдээний Номууд

Хичээл 1

Сайнмэдээний Номуудын Тойм

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Сайнмэдээний Номууд

Нэгдүгээр хичээл

Сайнмэдээний Номуудын Тойм

Агуулга

УДИРТГАЛ	1
УРАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ	1
Жанр.....	2
Түүхэн Хүүрнэл	2
Грек- Ромын Намтар	3
Библийн Түүхэн Хүүрнэл.....	6
Найдвартай Байдал	7
Баримтуудыг Ашиглах Боломжтой Байдал.....	7
Илэн Далангүй Байдал.....	8
Баталгаажсан Байдал	9
Дасгалжуулалт.....	10
Теологийн Итгэл Үнэмшил.....	11
Ариун Сүнс.....	12
ЧУУЛГАН ДАХЬ БАЙР СУУРЬ	13
Найруулга Зүй.....	13
Ижил төстэй байдал.....	14
Найруулга Зүйн Онолууд.....	16
Баталгаатай Байдал	17
Алдаа Мадаггүй Байдал	18
Найдвартай Бичээчид	19
Элчит Баталгаа	19
Чуулганы Гэрчлэл.....	20
НЭГДМЭЛ БАЙДАЛ.....	21
Нэг Ижил Түүх.....	21
Есүс	22
Нотолгоонууд.....	23
Үгсийн Сан	24
Үе Шатууд	26
ЯЛГААТАЙ БАЙДАЛ	28
Тодорхой Бэрхшээлүүд	28
Он цагийн дараалал	28
Хасалт.....	29
Өөр өөр Үйл Явдлууд.....	29

Өөр өөр үг Хэллэгүүд.....	30
Ялгаатай Онцлогууд.....	31
Матай номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?.....	32
Марк номд Есүсийг хэн гэж өг?	33
Лук номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?.....	36
Иохан номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?.....	38
ДҮГНЭЛТ.....	40
ХАМТРАГЧИД.....	42
ҮГСИЙН ТАЙЛБАР	44

Сайнмэдээний Номууд

Нэгдүгээр хичээл

Сайнмэдээний Номуудын Тойм

УДИРТГАЛ

Мэдээ бидний амьдралд хэр чухал болохыг та анзаарч байсан уу? Эргэн тойронд буй зүйлсийн талаар бидний олж сонссон чухал мэдээллүүд нь бидний үзэл бодол, үнэ цэн, төлөвлөгөө болон амьдралын бусад олон талбарт нөлөөлдөг. Зарим үйл явдлын мэдээ нь бидний ертөнцийг үзэх үзлийг бүр бүхлээр нь өөрчлөх хэмжээний чухал ач холбогдолтой байдаг. Тэгэхлээр, цааш нь бодож үзвэл Библи ч гэсэн өөрөө олон мэдээ мэдээллийн архивтай адил санагдана. Түүхийн туршид Бурханы хүмүүстэй холбоотой сайн муу бүхий л төрлийн мэдээг үүнд тэмдэглэсэн. Бас бид эдгээр түүхүүдийг судлах явцад энэ нь бидэнд олон талаар нөлөөлж, биднийг өөрчилж байдаг. Гэхдээ Бичвэрийн бидэнд өгүүлэх хамгийн шилдэг мэдээ бол мэдээний эмхэтгэл гэж хэлж болох “сайхан мэдээ” буюу “Сайнмэдээ” гэдэг нь эргэлзээгүй. Эдгээр нь бидний Их Эзэн, Аврагч Есүс Христийн мөн чанар ба үйлсийн талаар өгүүлэх амьдрал өөрчлөхүйц дурдатгалууд мөн.

Энэ бол бидний *Сайнмэдээний Номууд* цувралын эхний хичээл юм. Энэ цувралд бид Есүс Христийн амьдрал ба үйлчлэлийн тухай өгүүлэх Матай, Марк, Лук, Иохан нарын бичсэн номуудыг судлах болно. “Сайнмэдээний Номуудын Тойм” нэртэй энэ хичээлээр бид уг номуудыг илүү тодорхой ойлгож, өнөөгийн амьдралдаа бүрэн дүүрнээр хэрэгжүүлэхэд туслах чиг баримжааг олж авах болно.

Сайнмэдээний Номуудын Тойм хэсгээр бид дөрвөн гол асуудлыг хөндөх болно. Эхлээд бид Сайнмэдээний Номуудыг уран зохиолын төрлийн үүднээс нь судална. Хоёрдугаарт, бид эдгээр номуудын чуулганд эзлэх байр суурийг харах болно. Гуравдугаарт, бид Сайнмэдээний Номуудын хоорондын нэгдмэл чанарыг авч үзнэ. Дөрөвдүгээрт, бид эдгээрийн бие биеэс нь ялгаатай болгодог харилцан адилгүй талуудыг судлах болно. Ингээд эдгээр номуудын уран зохиолын төрлийн талаар эхлээд авч үзэцгээе.

УРАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ

Бид уран зохиол уншихдаа ихэвчлэн ямар төрлийн зохиол уншиж байгаа талаараа тодорхой мэдэрч, энэ нь биднийг хэрхэн унших болоод ямар хүлээлттэй байх ёстой гэдэг рүү чиглүүлдэг. Жишээлбэл, хэрэв та түүхэн роман уншвал энэ нь бодит баримттай түүх гэсэн хүлээлтгүй байх учраас төөрөлдөхгүй байх боломжтой. Эсвэл та цуврал богино өгүүллэг унших гэж байгаа тохиолдолд энэ нь үргэлжилсэн роман биш гэдгийг мэдэж, ийм байдлаар уншихгүй шүү дээ. Иймд бид ямар төрлийн зохиол уншиж байгаа талаараа болон уг зохиол нь тогтсон ямар хэв

маягийн дагуу бичигдсэн талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй.

— Доктор Ричард Баукхэм

Бид Сайнмэдээний Номуудын уран зохиолын төрлийг хоёр өнцгөөс нь судлах болно. Нэгдүгээрт, бид Сайнмэдээний Номуудын жанр буюу ерөнхий уран зохиолын ерөнхий онцлогийг авч үзнэ. Хоёрдугаарт, эдгээрийн түүхэн найдвартай байдлын талаар хэлэлцэх болно. Эхлээд сайнмэдээний дөрвөн номын жанрыг харцгаа.

ЖАНР

Ерөнхийдөө жанр гэдэг бол уран зохиолын хэв маяг эсвэл ангиллыг хэлдэг. Жанрууд нь ихэвчлэн уран зохиолын хэлбэр ба гүйцэтгэх үүргээрээ, тухайлбал өгүүлж буй арга барил, дүрслэлийн хэллэгийг хэрхэн ашиглаж байгаагаараа бие биеэсээ ялгагдана.

Библи нь олон янзын жанрыг агуулдаг. Жишээлбэл, түүхэн хүүрнэл болох Давидын тухай түүхүүд Хуучин Гэрээнд бий. Өөр нэг жанр бол Дууллууд болох яруу найргийн төрөл байдаг. Захидлууд бол өөр нэг жанр бөгөөд мөн эш үзүүлэлэг гэх мэтээр үргэлжилнэ. Уран зохиолын жанр бүр өөрийн гэсэн дүрэм журамтай, илэрхийлэх тогтсон арга барилтай байдаг. Тийм ч учраас Сайнмэдээний Номуудын жанрыг ойлгох нь бидэнд үнэхээр чухал юм. Хэрэв бид эхлээд тэдний *хэрхэн* зааж байгааг ойлговол юу зааж байгааг ойлгоход хялбар болно.

Сайнмэдээний Номууд өөр хоорондоо хэрхэн харилцан холбогддог болохыг ойлгохын тулд тэдний жанрыг гурван үе шаттайгаар тодорхойлон дүрслэх болно. Эхлээд бид Сайнмэдээний Номууд бол түүхэн хүүрнэл мөн гэдгийг ерөнхийд нь тодорхойлох болно. Хоёрдугаарт, бид тэдгээрийг Грек-Ромын намтар гэж нэрлэдэг түүхэн хүүрнэлийн онцгой хэв маягтай харьцуулах болно. Гуравдугаарт, бид Сайнмэдээний Номуудыг библийн түүхэн хүүрнэлтэй буюу Хуучин Гэрээний түүхүүдтэй харьцуулах болно. Юуны түрүүнд түүхэн хүүрнэлийг ерөнхийд нь ангилан авч үзэцгээе.

Түүхэн Хүүрнэл

Түүхэн хүүрнэлүүд нь өнгөрсөн хугацаанд амьдарч байсан хүмүүсийн тухай, тэдний амьдарч байсан өдрүүдэд болсон үйл явдал, үйл хэргийнх нь талаарх түүхүүд юм. Үндсэн түвшинд Сайнмэдээний Номууд нь Есүс Христийн амьдрал, үйлчлэлийг бичсэн учраас түүхэн хүүрнэлүүд мөн.

Бид өөрсдөө түүхэн бодит хүмүүс учраас Библийн болон Сайнмэдээний Номуудын дийлэнх хэсэг нь зориуд хүүрнэл хэлбэрээр бичигдсэн байдаг. Агуу түүхийн талаар уншиж байхдаа бид хар аяндаа л оюун санаа, сэтгэл хөдлөл, тэр ч байтугай бие махбодын хүртэхүйн түвшинд холбогддог. Мөн түүхүүд нь бусад хүмүүсийн амсаж туулсан зүйлсийг төсөөлөн, тэдгээрээс суралцан

урагшлахад маань бидэнд тусалдаг. Энэ бол түүхийн хүч чадлыг харуулж буй томоохон жишээ юм. Тиймээс Сайнмэдээний Номууд нь уран зохиолын хэлбэрээр буюу хүүрнэлийн хэлбэрээр бичигдсэн нь Есүсийн тухай үнэнийг мэдэж аваад зогсохгүй, Түүнийг өөрийн биеэр мэдэрч, Бурханы буюу тэнгэрийн хаанчлал хэрхэн биеллээ олж буйг харах боломжийг бидэнд олгодог. Мөн Есүсийн хайр энэрлийг зөвхөн "Есүс даруу хүмүүсийг хайрладаг" гэсэн үгсээс нь бус, харин даруу нь өргөмжлөгдөж, бардам нь дорд болгогддог түүхүүдийг ярьж мөн тийнхүү амьдарснаас нь харах боломжтой болгодог. Түүхүүд болон уран зохиолын хэлбэр бүхий Сайнмэдээний Номууд нь бидэнд Есүсийн үлгэр жишээг шавь нарынх нь адил дагах боломжийг олгодог. Түүхийг хүүрнэл хэлбэрээр бидэнд өгсөн явдал нь Есүсийг тийнхүү дагах боломжтой болгодог. Өөрөөр хэлбэл тэдгээр дүрүүдийн ололт, амжилт, уналт бүтэлгүйтэлтэй нь өөрсдийгөө адилтгаснаар бид өөрсдийн амьдралаа буюу өөрсдийн түүхээ итгэмжтэйгээр үргэлжлүүлэхэд тусалдаг.

— Доктор Жонатан Т.Пеннингтон

Эрт үеийн шашны зохиолуудад түүхэн хүүрнэлийг ихэвчлэн гурван үндсэн хэсгээр хөгжүүлэн бичдэг байв. Хүүрнэлийн эхэнд дүрүүдийг танилцуулж, дүрүүдийн хүрэх зорилгыг тогтоодог. Хүүрнэлийн дунд хэсэгт байнга л зорилгоо биелүүлэх гэсэн дүрүүдийн амжилтад саад, бэрхшээлүүд бий болно. Төгсгөлд нь үйл явдлын дүгнэлт хийгдэнэ. Энэ хэсэгт ихэвчлэн дүрүүд зорилгоо хэрхэн биелүүлсэн эсвэл биелүүлээгүйг харуулдаг гэсэн үг.

Сайнмэдээний Номууд яг ийм үндсэн тоймыг баримтална. Ном тус бүр Есүсийг түүхийн гол дүр гэж танилцуулан эхлэх ба Бурханы хаанчлалаар дамжуулан авралыг авчрах Түүний зорилгыг дүрсэлдэг. Ном тус бүр нь Есүсийн эрх мэдэл ба үйл хэрэгт сорилт бэрхшээлүүд тулгарч буйгаар үргэлжилнэ. Мөн ном тус бүр Есүсийн дэлхий дээрх үйлчлэлийн үр дүнг тайлбарласнаар төгсдөг. Эдгээр ижил төстэй байдлын улмаас түүхэн хүүрнэл нь Сайнмэдээний Номуудын гол жанр гэдэгтэй бараг бүгд санал нийлдэг.

Грек-Ромын Намтар

Сайнмэдээний Номууд нь түүхэн хүүрнэлийн ерөнхий том ангилал доторх нэг дэд төрөл ангилал болох Грек-Ромын намтар гэгдэх хүүрнэлийн төрөлд багтана гэж зарим тайлбарлагчид үздэг.

Сайнмэдээний Номууд ба Грек-Ромын намтар хоёрын харьцуулалтыг бид хоёр үе шаттайгаар авч үзнэ. Эхлээд бид тэдгээрийн ижил төстэй байдлыг харна. Хоёрдугаарт, бид зарим ялгааг авч үзэх болно. Ингээд ижил төстэй байдлаас нь эхэлцгээе.

Ижил төстэй талууд. Эртний намтрууд нь агуу удирдагчдын амьдралыг

өгүүлсэн байдаг. Хэдий тэдгээр нь олон янзын дүр ба түүхүүдийг багтаадаг ч Грек-Ромын намтарт эдгээрийн талаар өгүүлэхдээ удирдагчийг онцолсон байдлаар дүрсэлсэн байдаг. Тэдгээр нь удирдагчийн үзэл санаа болоод үйл хэргийнх нь талаарх ойлголтыг үеэс үед хадгалсаар ирсэн байдаг. Сайнмэдээний Номууд нь эртний намтруудтай энэ талаараа тун төстэй.

Сайнмэдээний дөрвөн номууд бүгд Есүсийн үхлийг нарийвчлан дурдаж, Матай, Лук ном нь Түүний төрөлтийн талаарх хүүрнэлийг оруулсан байдаг нь эртний намтруудтай ижил төстэй байдаг. Сайнмэдээний Номууд нь Есүсийн амьдралын үйл явдлуудыг дурдахдаа эртний намтарт бичигддэг тогтсон загварыг мөн баримталсан. Яг л эртний намтар бичигчдийн адил Сайнмэдээний бичээчид Есүсийн төрөлт болон үхлийн хоорондох үйл явдлуудыг янз бүрийн арга замаар эмхэлсэн. Заримдаа эдгээр нь аливаа зүйлсийг он цагийн дарааллаар эрэмбэлсэн байдаг. Харин заримдаа юмсыг сэдвийн дагуу бүлэглэсэн байдаг бол заримдаа бүр газарзүйн байрлалынх нь дагуу дараалуулсан байдаг.

Миний бодлоор юуны түрүүнд Сайнмэдээний Номууд нь ерөнхийдөө он цагийн дарааллаар байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал. Жишээлбэл, эдгээр нь Баптист Иоханаар баптисм хүртээлгэж буй үйл явдлаар эхэлдэг. Дараа нь Есүс баптисм хүртэж байгааг та олж харна. Тэгээд Есүсийн үйлчлэл, Түүний баривчилгаа, шүүх хурал, цовдлол ба амиллын талаар өгүүлдэг. Тэгэхлээр эдгээр нь ерөнхийдөө он цагийн дараалалтай гэсэн үг. Үүний зэрэгцээ хэрэв та Сайнмэдээний хоёр номыг харьцуулж үзвэл заримдаа үйл явдлууд, эсвэл үг хэллэг нь өөр өөр дараалалтай байх тохиолдол ч бий. Хэрэв бид Сайнмэдээний Номууд нь бүх талаараа маш нарийн он цагийн дараалал өгөхийг зорьж байгаа гэж үзвэл асуудал үүсэж болох юм. Гэхдээ ихэнх зохиолчид, бүхий л төрлийн хүүрнэлүүд нь тухайн зохиогчид үүнийгээ он цагийн дарааллаас өөр дарааллаар эмхлэх боломжтой байдаг. Жишээлбэл, бид тэдгээрийг логик дараалал эсвэл сэдвийн дагуу бүлэглэсэн болохыг харж болдог. Эртний Христитгэгчид, жишээлбэл, IV зууны эхэн үеийн Христэч түүхч, бишоп Иосефус Сайнмэдээний номын үйл явдлын дараалал нь хэдийнээ тодорхой байсан нь ойлгомжтой байсан гэж үзсэн. Анхны уншигчид үүнийг төвөггүй ойлгодог байсан. Учир нь тэд анхнаасаа цаг хугацааны хатуу чанд дарааллыг чухалчлаагүй байдаг.

- Доктор Дэвид А.Ределингс

Грек-Ромын намтруудын бас нэг чухал шинж чанар нь өнгөрсөн үйл явдлуудыг түүхэн бодит байдал гэж хандсанаараа өнгөрсөн үеийг одоогийнхоос ялгадаг явдал юм. Намтрууд нь тодорхой, түүхэн хувь хүмүүсийн өвөрмөц, давтагдашгүй амьдрал болоод хувь нэмрийг тэмдэглэхэд чиглэдэг.

Ер нь эртний намтар бичигчид аман болон бичгийн тэмдэглэлүүдийг үнэн зөв судалж, хадгалан хамгаалахыг хичээдэг байв. МЭ 46-120 оны хооронд амьдарч байсан нэр хүндтэй намтарч Плутархын бичсэн жишээг авч үзье л дээ. Плутарх бол

МЭ 70-аад оны үед буюу Сайнмэдээний Номууд бичигдсэнтэй ижил цаг үед бүтээлээ туурвисан Грекийн шашингүй үзэлт түүхч байв. Тэрээр *"Цицероны амьдрал"* бүтээлээ Цицероны эцэг эхийн тухай өгүүлж эхэлсэн боловч Цицероны эцгийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал гэдгийг хүлээн зөвшөөрсөн харагддаг. Плутархын *"Цицероны амьдрал"* зохиолоос дараах хэсгийг хамтдаа сонсогтооё:



Плутарх

Энд Цицеронын эх Хелвиаг баян айлд төрсөн бөгөөд шулуун шударга амьдарсан тухай ерөнхийд нь өгүүлдэг. Харин эцгийнх нь тухайд ямар ч зүйл тэмдэглэгдээгүй байдаг. Гэвч зарим нь түүнийг худалдааны талаар бүрэн мэдлэг, боловсролтой хүний хүү байсан гэж үзэж байв. Бусад нь түүний гарал угсааг Ромчуудын эсрэг дайн эхлүүлсэн Волскичуудын цуутай хаан Туллус Аттиустай холбож тайлбарладаг.

Цицероны эцэг эхийн талаарх таамаглалаас баримтыг салгаж буй Плутархын болгоомжлол нь ядаж зарим эртний намтарчид түүхийн нарийн ширийн зүйлсийг анхаарч, үнэн зөвийг сонирхож байсныг харуулна. Үүнчлэн Сайнмэдээний Номууд нь өөрсдийн хүүрнэж буй зүйлсийн нарийн ширийнд яг л Плутарх шиг болгоомжтой хандсан нь тодорхой байдаг.

Өргөн утгаараа Сайнмэдээний Номууд нь Грек-Ромын ертөнцөд намтарчилсан зохиол дэлгэрч байх үед бичигдсэн түүхэн хүүрнэлүүд юм гэж хэлэх нь зүйтэй. Намтарт өргөн тархсан энэхүү ил тодорхой байдал нь магадгүй Сайнмэдээний бичигчдийг үүргээ гүйцэтгэхэд нь зоригжуулж, эдгээр намтруудыг зарим тогтсон хэв маягийн дагуу бичихэд нь түлхэц болсон байх.

Гэхдээ Сайнмэдээний Номууд болон Грек-Ромын намтруудын хооронд ижил төстэй зүйл байгаа ч мэдэгдэхүйц ялгаанууд ч бас бий.

Ялгаанууд. Хэдийгээр бид хэд хэдэн ялгааг дурдаж болох ч зөвхөн гурав дээр нь анхаарлаа хандуулах болно. Нэгдүгээрт, Сайнмэдээний Номуудын хүлээн авагчид нь Грек-Ромын намтрынхаас ялгаатай байдаг.

Эртний намтрууд нь ихэвчлэн өргөн хүрээний хүмүүст зориулагдсан байдаг бол Сайнмэдээний Номуудыг анхны Христийн чуулган гэсэн онцгой сонсогчдод зориулж бичсэн. Хэдий тэд намтрын тодорхой шинж чанаруудыг харуулдаг боловч үндсэндээ чуулганы итгэл сүсгийн хэрэгцээнд зориулагдсан гэсэн үг. Энэхүү онцлог нь тэдгээр бичигдсэн зүйлс нь хэр хурдан чуулганы сургаал, мөргөлд тогтмол хэрэглэгдэх болсноос харагдана.

Хоёрдугаарт, Сайнмэдээний Номууд нь намтар зохиолоос өөрсдийн онцолж буй зүйлсээрээ ялгагддаг. Грек-Ромын намтрууд нь гол дүрүүдийн хувийн шинж чанаруудыг ихэнхдээ онцолж, бусад хүмүүсийг тэдний амьдрал, зан чанарыг дуурайхад урамшуулдаг. Хэдийгээр Есүсийн амьдрал олон талаараа бидний үлгэр жишээ болдог ч Сайнмэдээний Номууд нь огт өөр зүйлд төвлөрдөг. Тэд Есүсийн хосгүй цор ганц байдлыг онцолдог. Эдгээр нь Есүс бол Бурханыг илчилж, ард түмнээ зольж аварсан Нэгэн гэдэгт төвлөрдөг. Хэн ч үүнийг хийж чадаагүй юм. Тийм ч

учраас Сайнмэдээний Номуудын ихэнх хүүрнэл нь Есүсийн амьдралын сүүлчийн долоо хоног буюу Зовлонгийн долоо хоногийн тухай өгүүлдэг байна.

Гуравдугаарт, Сайнмэдээний Номууд болон эртний намтрууд нь өөр өөр соёлыг төлөөлдөг. Намтрууд нь Грек-Ромын хүсэл зориг, үнэт зүйл, амьдралын хэв маягийг илэрхийлсэн. Харин Сайнмэдээний Номууд нь Еврейн соёл, ялангуяа Хуучин Гэрээний соёлын нөлөөг их авсан байдаг. Энэ нь Грекийн соёл, сэтгэлгээний нөлөөг хамгийн ихээр авсан байдаг Лукийн сайнмэдээнд хүртэл тодорхой харагддаг юм.

Дээрх бүгдээс дүгнэвэл Сайнмэдээний Номууд болон Грек-Ромын намтруудын хооронд мэдэгдэхүйц ижил төстэй зүйлс бий. Мөн эдгээр ижил төстэй байдал нь Сайнмэдээний Номуудын утга учирт зарим нэг чухал ойлголтыг нэмж өгнө. Гэхдээ тэдний хоорондох мэдэгдэхүйц ялгааг харгалзан үзвэл Сайнмэдээний Номууд нь Грек-Ромын намтар гэх жанрт яв цав тохирохгүй байгаа нь тодорхой байна.

Тэгэхээр нэгэнт бид Сайнмэдээний Номуудыг ерөнхий түүхэн хүүрнэл болоод Грек-Ромын намтар мөн эсэх талаас нь авч үзсэн тул одоо библийн түүхэн хүүрнэлийн жанртай харьцуулахад бэлэн боллоо.

Библийн Түүхэн Хүүрнэл

Сайнмэдээний Номууд нь ердийн түүхэн хүүрнэл, тэр ч байтугай Грек-Ромын намтартай төстэй байдгийн адилаар Хуучин Гэрээний түүхэн хүүрнэлүүдтэй тун ч төстэй байдаг. Гэхдээ бид үүнд гайхах хэрэггүй. Угтаа Хуучин Гэрээний хүүрнэлүүд нь Сайнмэдээний бичээчдийн ариун Бичвэрүүдийн нэг хэсэг байсан шүү дээ. Сайнмэдээний бичээч бүр Хуучин Гэрээнээс олон эшлэл авсныг харахад тэд Хуучин Гэрээг өнөөгийн ихэнх Христитгэгчдээс хавь илүү сайн мэддэг байсан гэдэгт бид итгэлтэй байж болдог. Мөн тэд ийнхүү Хуучин Гэрээг сайтар мэддэг байсан нь тэдний үүрэг даалгавартаа хэрхэн хандаж буйд нь нөлөөлсөн гэсэн үг.

Цаашлаад Сайнмэдээний бичээчид болон Хуучин Гэрээний түүхэн хүүрнэлийн бичээчдийн зорилго ижил байсан. Тодруулбал, энэ нь ард түмэнтэйгээ байгуулсан Бурханы гэрээг тайлбарлаж, хамгаалах явдал байв. Нэг жишээ татахад, Гэтлэл 1-19-р бүлэг дээрх түүхэн хүүрнэлүүд нь Гэтлэл 20-24-р бүлэг дэх Мосегийн Гэрээний түүхэн үндэс суурь болдог.

Энэхүү зорилго нь Гэтлэл 24:8 дээр тодорхой байдаг бөгөөд бид дараах хүүрнэлийг харж болдог. Энд:

"Тиймээс Мосе цусыг авч ард түмний дээгүүр цацан "—Үзэгтүн, энэ бол эдгээр бүх үгийн дагуу ЭЗЭНий та нартай байгуулсан гэрээний цус" юм гэв (Гэтлэл 24:8).

Библийн бусад хүүрнэлүүд болох Иошуа 1–23-р бүлэг нь гэрээний шинэчлэлийн үндэс суурь болдог. Шүүгчдийн ном болоод 1 Самуел номуудын хүүрнэлүүд нь 2 Самуел 7-р эшлэл дэх Давидын Гэрээний түүхэн үндэс юм. Үүнчлэн Сайнмэдээний Номууд нь Есүсийн байгуулсан Шинэ Гэрээний түүхэн үндсийг хангаж өгдөг.

Лук 22:20 дээрх Лукийн хүүрнэл нь бидний сая уншсан Гэтлэл 24:8 дээрх

түүхтэй хэрхэн нийцэж байгааг сонсоцгооё:

"Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч, "—Энэ аягатай бол та нарын төлөө урсах Миний цусаар тогтоогдох шинэ гэрээ" юм гэжээ (Лук 22:20).

Дээрх бүгдээс дүгнэвэл Сайнмэдээний Номуудыг бусад алдартай уран зохиолын жанруудтай харьцуулахад эдгээр нь библийн түүхэн хүүрнэлүүдтэй хамгийн төстэй болох нь харагдаж байна. Гэхдээ үүгээрээ тэд бусад библийн түүхэн хүүрнэлүүдтэй бүх талаараа яг адилхан юм гэж хэлж болохгүй. Ямартай ч тэдгээр нь Грек-Ромын намтруудын зарим шинж чанарыг өөртөө тусгасан нь үнэн. Энэ утгаараа бид Сайнмэдээний Номуудыг библийн түүхэн хүүрнэлийн шинэ төрөл гэж хэлж болох юм. Тиймээс энэ нь Сайнмэдээний номуудыг уншиж байх үед эдгээрийг юун түрүүнд библийн түүхэн хүүрнэл гэж бодоход бидэнд тусална. Гэхдээ бид бас эдгээр нь Есүсийг онцолсон Түүний намтар гэж харан, бусад дүрүүдийг Түүнтэй хамааралтайгаар тайлбарлах хэрэгтэй.

Ингээд бид Сайнмэдээний Номуудын жанрыг судалсан тул одоо Есүсийн талаарх түүхэн дурдатгал болох Сайнмэдээний Номуудын найдвартай байдлын тухай авч үзэхэд бэлэн боллоо.

НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Түүхийн туршид найдвартай, найдваргүй түүхчид болон найдвартай, найдваргүй эх сурвалжийн хоорондох ялгааг байнга л ялгаж салгасаар ирсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор Сайнмэдээний Номуудын бичээчдийн Есүсийн амьдралын талаарх эдгээр хүүрнэл нь найдвартай юу?, найдваргүй юу? гэдэг чухал асуулт урган гардаг. Орчин үеийн бидний шалгуур нь тэдний дагаж мөрдсөн шалгууртай адил биш боловч Матай, Марк, Лук, Иохан нар Есүсийн тухай үнэн баттай түүхийг бичих хангалттай эх сурвалж, хүсэл эрмэлзэлтэй байсан гэдгийг нотлох олон баримт бий.

Сайнмэдээний дөрвөн Ном Есүсийн амьдралын найдвартай түүхэн тэмдэглэл гэдэг нь тоо томшгүй олон баримтаар батлагддаг ч бид зөвхөн зургаан нотлох баримт дээр анхаарлаа хандуулах болно.

Баримтуудыг ашиглах боломжтой байдал

Нэгдүгээрт, Сайнмэдээний Номуудын бичээчид өөрсдийн тэмдэглэсэн үйл явдлуудын талаарх баримтуудыг ашиглах боломжтой байв. Яг өнөөгийн цаг үетэй нэгэн адил эртний ертөнцөд найдвартай сайн түүхчид нь өөрсдийн сэдэвтэй холбоотой олон баримтыг ашиглах боломжтой байхыг шаарддаг байсан. Ромын түүхч Плутархыг дахин нэг санацгаая. Тэрээр *Демосфений амьдрал* номын оршилдоо түүхч хүн ажлаа хэрхэн хийх ёстой талаар тухайн соёлынхоо нийтлэг хүлээлт, шаардлагыг ийнхүү дурдсан. Тэрээр энд:

“Хэрэв хэн нэгэн хүн түүх бичих гэж байгаа бол... юуны түрүүнд,

хамгийн чухал нь ... олон төрлийн хангалттай номтой байх явдал юм. Ингэснээр уг зохиол зохиолчдын үзгээс халин гарч, хүмүүсийн ой тойнд өөрийн онцлогоороо хадгалагдан үлдэхэд хэрэгцээтэй аливаа зүйлсээр дутагдахгүй байх боломжтой” гэжээ.



Плутарх

Эндээс харж байгаагаар Плутарх найдвартай түүхч хүн найдвартай эх сурвалжтай холбогдох шаардлагатай гэдэгт бат итгэлтэй байсан. Мөн тэрээр бичгийн ба амаар уламжлагдсан ирсэн бүх боломжит эх сурвалжуудад ихээхэн ач холбогдол өгсөн байдаг.

Сайнмэдээний Номын бичээч бүр Есүсийн амьдралыг нүдээр үзсэн гэрч нар эсвэл Есүсийн амьдралыг нүдээр харсан хүмүүстэй шууд харилцаатай хүмүүс байсан. Матай, Иохан нар Есүсийн дагалдагчид байсан учраас тэмдэглэсэн үйл явдлынхаа ихэнх хэсэгт өөрсдөө шууд оролцсон байдаг. Марк Петрийн дотны хамтрагч байсан бөгөөд шууд түүнээс суралцсан. Лук Паултай хамт аялж, өөрийн Сайнмэдээний найдвартай гэрчүүдийг хайж байжээ. Лук 1:1-3 багцад Лук юу гэж бичсэнийг сонсоцгооё. Энд:

“Бидний дунд биелсэн үйл явдлуудын тухай хүүрнэлийг олон хүн эмхэтгэхийг хичээсэн билээ. Анхнаас нь нүдээр үзсэн гэрчлэгчид хийгээд үгийн үйлчлэгч бологсдоос бидэнд уламжилсны адил би ч бас энэ бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд дэс дараалан бичиж өгөх нь зүйтэй юм” гэжээ (Лук 1:1-3).

Илэн далангүй байдал

Хоёрдугаарт, бид Сайнмэдээний Номуудын түүхэн найдвартай байдлыг тэд эдгээрийг маш илэн далангүй бичсэн байдгаас нь харж болно. Сайн түүхийг бичих эртний жишгүүд нь түүхчдээс түүхийг ний нуугүй илэн далангүй өгүүлэхийг шаарддаг байв. Тэднээс олон нарийн ширийн зүйлсийг мэдээлэхийг шаарддаг бөгөөд үүнд нь дүрсэлж буй мэдээ нь таагүй байсан ч хамаагүй байв.

Энэ утгаараа Сайнмэдээний Номуудын бичээчид Есүсийн дагалдагчдын бүтэлгүйтлийг үргэлж л дүрсэлсэн байдаг нь тун ач холбогдолтой байдаг. Тэгэхлээр Матай, Иохан нарын хувьд энэ нь өөрсдийн алдаагаа дүрсэлсэн гэсэн үг юм. Хэрэв зарим тайлбарлагчдын хэлж буй шиг Марк 14:51-52-р хэсэг дэх Гетсемани цэцэрлэгээс нүцгэн зугтсан залуу Марк өөрөө гэж үзвэл тэрээр өөрийн бүтэлгүйтэл дутагдлаа ний нуугүй дэлгэсэн гэсэн үг. Сайнмэдээний Номуудын бүх бичээчид Есүсийн дагалдагчдын бүтэлгүйтлийг бүхэлд нь илчилсэн. Үүгээрээ тэд нялх балчир буй анхны чуулганы удирдагчид нь төгс байдлаас хэр хол байгааг хүлээн зөвшөөрсөн.

Нэг л жишээ дурдахад, Есүс 5,000 хүнийг гайхамшгаар хооллож байсныг дагалдагчид нь ойлгож чадаагүй болохыг Марк 6:51-52 дээр өгүүлдэг. Энд:

“Тэд маш ихээр гайхацгаав. Учир нь тэд талхны явдлыг ойлгоогүй, харин ч зүрх нь хатуу байв” гэжээ (Марк 6:51-52).

Сайнмэдээний номын бичээчид Есүсийн дагалдагчдын үл ойлголцол, ёс суртахууны алдааг ар араас нь мэдээлж байсан. Гэвч хэрэв эдгээр бүтэлгүйтлийг дурдах нь чуулганы удирдагчдын эрх мэдэл, хүндэтгэлтэй байдлыг нь дордуулах магадлалтай байсан бол тэд яагаад үүнийг оруулсан юм бол?

Сайнмэдээний Номуудад дагалдагчдыг төгс биш, төгс ойлгодоггүй гэж танилцуулсан нь олон уншигчдын санааг зовоодог. Нэг зүйлийг хэлэхэд Сайнмэдээний уламжлалын найдвартай байдлыг харуулах гэсэндээ манай сайнмэдээний номын бичээчид чуулганы анхны удирдагчдыг айхтар муу биш ч тийм ч сайнгүй байдлаар дүрсэлж орхижээ гэж би боддог. Тэгэхээр энэ нь нэг ёсондоо бидний Сайнмэдээний найдвартай, үнэн зөвийг гэрчлэх чухал тал нь мөн.

- Доктор Дэвид Р.Бауэр

Дагалдагчид өөрсдийн түүхээрээ өөрсдийгөө муухай харагдуулж байгаа нь үнэндээ Сайнмэдээний Номуудын үнэн зөвийг батлах хамгийн хүчтэй баримтуудын нэг гэж би танд хэлмээр байна. Хэрэв та Вавилон юм уу Ассирийн хаад, эсвэл Ромын хаадын тухай эртний түүхийг уншвал тэд зүгээр л амжилтаас амжилтад, ялалтаас ялалт руу явсан байгаа харагддаг. Эдгээрт өгүүлэхдээ "Энэ бол миний гайхамшигт алдар гавьяа!" гээд л хөвөрнө. Тэгээд бид мэдээж хэрэг эдгээрийг уншаад, за тэгвэл үнэхээр яг юу тохиолдсон юм бол? гэж хэлдэг. Тэгвэл бид дагалдагчдыг хараад юу гэх вэ? ... та ингээд л бодоод үз. Ямар толгой нь эргэсэн хүн гэхээрээ ром болоод ромын засаглалын эсрэг бослого үймээн дэгдээж, хууль зөрчиж, иудейчүүдийн хараал зэвүүцлийг төрүүлсэн хэргээр яллагдан цовдлогдсон нөхрийг баатраа болгоод шашин шүтлэг зохиогоод явдаг байна аа. Тэгээд тэдгээр толгой нь эргэсэн нөхдүүд нь номынх нь анхны хүлээн авагчид нь гэж байгаа. Хэрэв үнэхээр тохиолдоогүй л бол та ийм зүйл хэзээ ч зохиохгүй шүү дээ.

- Доктор Дан Дориани

Баталгаажсан байдал

Гуравдугаарт, Сайнмэдээний бичээчдийн найдвартай гэдэгт итгэх итгэл

маань бусад түүхийн эх сурвалжаар баталгааждаг. Ромын болон Еврейн түүхчид Сайнмэдээний Номын хүүрнэлүүдийн хэд хэдэн мэдэгдлүүдийг баталж, орчин үеийн археологийн олдворууд ч тэдний дурдсан бүхэн үнэн болохыг нотолсон.

Жишээлбэл, залуу Плиний, Суетониус, Тацитус, Юлиус Африканус зэрэг Грек-Ромын түүхчид Есүсийн амьдрал, цовдлол, мөн үзүүлсээр буй нөлөөлөл зэргийн талаарх зарим үндсэн мэдээллийг дурдсан.

Тэгэхээр еврей түүхч Иосефус МЭ 1-р зуунд Ромын удирдлагад зориулан иудейчүүдийн түүхийг бичиж байхдаа Есүс Христийг бодитоор амьдарч, олон дагалдагчидтай байсан гэж дурдсан байдаг. Манай эриний өмнөх 1-р зуунд буюу Иосефустай нэг үед амьдарч байсан Ромын түүхч Тацитус ч мөн Есүс Христийн тухай болоод Тэрээр олон дагалдагчидтай байсан тухай нь өгүүлсэн нь бий. Еврейн Талмуд хүртэл Есүс үнэхээр байсан гэж дурдсан байдаг.

- Доктор Стивен Цоукалас

Нэгдүгээр зууны Палестин дах нэгэн Иудейн талаар бид одоо 50 жилийн өмнөхөөс хамаагүй их зүйлийг мэдэж байгаа. Энэ утгаараа Сайнмэдээний Номуудын найдвартай байдлыг өмнөхөөсөө илүү сайн авч үзэх боломжтой болсон гэж би боддог. Үүнийг бид Мөхсөн Тэнгисийн Хуйлмал бичээсүүд зэрэг археологийн үнэт олдвор, тэдгээрийн уран зохиолын нээлтүүдээр дамжуулан мэдэх боломжтой. Мөн Ариун газар дахь археологийн олдорууд, шинэ шинэ нээлтүүд ар араасаа гарсаар байна. Тиймээс бид Есүсийн үйлчлэл ямар түүхэн нөхцөлд өрнөсөн болохыг илүү их мэддэг болж байна. Мөн Сайнмэдээний Номуудад дурдсан зүйлс тухайн түүхэн нөхцөлтэйгөө баттай нийцэж байгаа эсэхийг бид асууж мэдэх янз бүрийн арга зам байдаг. Иймэрхүү тодорхой түүхэн нөхцөлд Есүсийг еврей багш гэж харах нь нийцэж байна уу? Ерөнхийдөө энэ нь маш сайн тохирч байна гэж би бодож байна. Ялангуяа 66-70 оны еврейчүүдийн бослогын дараа еврейн Палестин дахь нөхцөл байдал эрс өөрчлөгдсөнийг бид мэдэж байгаа. Тиймээс Сайнмэдээний Номууд нь тэр бослогын дараах Еврейчүүдийн нөхцөл байдлыг дүрслээгүй нь тухайн үеээс өмнөх багахан цаг хугацаанд бичигдсэн гэдэг нь тодорхой. Үүнийг нотлохын тулд бид 1-р зууны Иудезмийн тухай мэдэх бүх зүйлээ шавхах ч албагүй.

- Доктор Ричард Баукхэм

Дасгалжуулалт

Сайнмэдээний хүүрнэлд итгэх дөрөв дэх шалтгаан бол Есүсийн дагалдагчдын хүлээж авсан дасгалжуулалт нь Есүсийн үгс, үйлдлүүдийг хэрхэн үнэн зөв тэмдэглэж үлдээхийг тэдэнд заах хэрэгтэй байсантай холбоотой.

Еврейн соёл дотор дагалдуулал нь өргөн тархсан амьдралын хэв маяг байв. Үнэндээ дагалдагч гэх еврей үгийг *талмид* гэх бөгөөд сурагч эсвэл суралцагч гэсэн утгатай. Тодруулбал, дагалдагч гэдэг нь тодорхой мэргэн хүний эсвэл раббигийн сурагчийг хэлдэг байв. Түүнчлэн Есүсийн үеийн еврейн соёлд раббигаас суралцах гол дасгалуудын нэг нь цээжлэх явдал байжээ. Мөн түүний дагалдагч нарын нэг үүрэг бол багшийнхаа үг ба мэргэн ухааныг сурах явдал байв.

Лук 6:40-р эшлэлд Есүсийн дагалдагч нартаа хэлсэн үгийг сонсоцгооё. Энд:

“Шавь нь багшийнхаа дээгүүр байдаггүй. Бүрэн суралцах аваас хэн ч багш шигээ болж болно” гэжээ (Лук 6:40).

Үүгээр Есүс Өөрийг нь дагадаг хүн бүр Өөрийнх нь үг сургаал, үйл хэргийг судалж, суралцан, амьдралаа тэдгээрээр хэлбэршүүлэх ёстой гэжээ.

Есүстэй хамгийн ойр байсан арван хоёр дагалдагчдад нь Есүсийн сургаалуудыг сурах их үүрэг хариуцлага ирсэн бол Есүсээс суралцсан бусад олон хүн ч мөн адил Түүний үг сургаалыг ой тойндoo хадгалах гэж хичээсэн нь лавтай.

Теологийн итгэл үнэмшил

Тавдугаарт, Сайнмэдээний бичээчид үнэн бөгөөд найдвартай тэмдэглэл хэрэгтэйг онцолсон теологийн хүчтэй итгэл үнэмшилтэй байсныг бид яагаад ч дутуу үнэлж болохгүй. Жишээлбэл, Иохан 20:31 дээр элч дараах үгсийг бичсэн. Энд тэрээр:

“Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгээсэй гэсэндээ эдгээр нь бичигдсэн юм. Тийнхүү итгэснээрээ та нар Түүний нэрээр амьтай болох юм” гэжээ (Иохан 20:31).

Энэ багц хэсэгт Иохан хүмүүс Есүсийн тухай *үнэнийг* мэдэж, хүлээн зөвшөөрч байж л Бурханы амийн бэлгийг хүлээн авах боломжтой гэдгийг шууд тодорхой хэлсэн.

Үүнтэй адилаар Матай өөрийнхөө Сайнмэдээний номын 28:19-2-р эшлэлд Есүсийн хэлсэн үгсийг тэмдэглэжээ. Энд:

“—Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуул. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа” гэжээ (Матай 28:19-20).

Энд Матай дагалдагчдыг Есүсийн тушаасан бүхнийг заах үүрэгтэй гэжээ. Есүсийн

жинхэнэ дагалдагчдын хувьд тэрээр Түүний хийсэн, хэлсэн зүйлсийн талаар үнэн зөв тэмдэглэлийг бичиж үлдээх хэрэгцээг үл тоомсорлох боломжгүй байв.

Сайнмэдээний бичээчид Есүсийн амьдралын үйл явдлуудыг зөвхөн түүхэн үнэ цэний үүднээс тэмдэглээгүй. Эсрэгээрээ тэдний Есүст итгэх итгэл нь Түүний тухай түүхэн баримтуудыг л мэдэх явдлаас хамаагүй илүү гэдгийг мэдэж байв. Гэвч тэд жинхэнэ итгэл нь худал эсвэл төөрөгдүүлсэн түүхэн тэмдэглэл дээр үндэслэх боломжгүй гэдгийг бас мэдэж байлаа. Тэд уншигчдыг түүхэн бодит Есүс болох жинхэнэ Есүст итгээсэй гэж хүссэн учраас Есүсийн үг, үйлдлийг тодорхой бөгөөд үнэн зөв илэрхийлсэн.

Ариун Сүнс

Зургаадугаарт, Библийн бусад бүхий л бичээчдийн адил Сайнмэдээний Номын бичээчид Есүсийн үг ба үйл хэргийн тухай тэмдэглэлээ бичихийн тулд цор ганцаараа хөдөлмөрлөсөнгүй. Ариун Сүнс тэднийг энэ зүтгэлд нь хөтөлсөн.

Бичвэрийн онгод оруулалт бол амин чухал онол сургаал юм. Яагаад гэвэл энэ нь бүх Бичвэрийг туйлын ганц зохиогчтой болгодог. Тиймээс, бид Сайнмэдээний Номуудыг харах үедээ дөрвөн өөр бичигч Есүсийн талаар дөрвөн өөр өнцгөөс илэрхийлж байгаад талархаад зогсохгүй эдгээрийг бүгдийг нь Ариун Сүнс онгод оруулсан гэдгийг мэдэх хэрэгтэй. Тэд теологийн хувьд өөрсдийн гэсэн ялгаатай сэдэлтэй байсан. Мөн бичиж буй хүлээн авагчид нь ч, Есүстэй харилцсан туршлага нь ч, нөхцөл байдал нь ч тэр өөр өөр байсан. Хэдий эдгээр нь өөр өөр ялгаатай хүмүүн бичээчдэд тулгуурласан боловч тэдний дотор гайхалтай нэгдмэл чанар бий. Бичвэрийн Сүнсний онгод нь хүмүүний оролцоо, үйл хэргийг хүчингүй болгодоггүй. Харин Бурхан эдгээр хүмүүсийн зүтгэлээр дамжуулан Өөрийн яг хүссэн санаагаа бичүүлсэн юм аа.

- Доктор К.Эрик Тоеннес

Иохан 14:25-26 дээрх Есүсийн үгийг хамтдаа сонсоцгооё. Энд:

“Би та нартай хамт байхдаа эдгээрийг хэллээ. Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүгдийг заах бөгөөд та нарт хэлсэн бүгдийг минь сануулах болно” гэжээ (Иохан 14:25-26).

Есүсийн дагалдагч нарын цээжлэх ой хэчнээн сайн байлаа ч бүгдийг нь мэдэж тогтоох боломжгүй юм. Тийм учраас Есүс Өөрийн элч нартаа Ариун Сүнсийг амлаж, илгээсэн. Мөн Есүсийн юу үйлдэж, бас өгүүлснийг чуулган зуун зууны турш санаж байх боломжийг Ариун Сүнс нээж өгсөн. Иохан өөрийн Сайнмэдээнийхээ номын 21:25-р эшлэлд энэ тухай өгүүлдэг. Тэрээр:

“Есүсийн үйлдсэн өөр олон үйлс бий. Хэрэв тэдгээрийг нэг бүрчлэн бичсэн бол бичигдсэн номууд нь энэ дэлхийд багтахааргүй байх байсан гэж би боддог” гэжээ (Иохан 21:25).

Есүсийн тухай хүмүүстэй ярилцах нь сонирхолтой байдаг. Хэрэв та хэн нэгнээс Есүс гэж хэн бэ гэж асуувал зарим хүмүүс Түүнийг рабби, эсвэл Тэр бол багш юм гэж хэлэх байх. Эсвэл та дэлхийн янз бүрийн шашин, өөр өөр бүлэг хүмүүс Түүний талаар олон янзын ойлголттой байдаг гэдгийг олж харна. Гэвч Бурхан Өөрийн мэргэн ухааныхаа дагуу, Ариун Сүнсээрээ дамжуулан нүдээр үзсэн гэрч нараа итгэлийг хадгалан авч үлдэх дөрвөн хүүрнэлийг бичихэд удирдсан юм. Ийнхүү өнөөдөр бидэнд Матай, Марк, Лук, Иохан ном байгаа юм шүү дээ. Ингэхдээ бичээч өөртөө, эсвэл өөрт буй эх сурвалжуудад тулгуурласан байх нь чухал биш бөгөөд хамгийн гол нь бидэнд нүдээр үзсэн гэрч нарын Ариун Сүнсээр хамгаалагдсан гэрчлэл бий. Энэ нь гол шалгуур болдог. Тиймээс хэрэв хэн нэгэн "Есүс үүнийг ингэж хэлсэн, эсвэл Есүс үүнийг хийх байсан, Есүс үүнийг хийхгүй байсан" гэж хэлбэл тэдгээрийг нягталж харах няцаагдашгүй баримт бидэнд байгаа юм. Бурхан эдгээрийг итгэлийн маань тулгуур чулуу болгон бидэнд өгсөн билээ.

- Доктор Роберт Л.Плуммер

ЧУУЛГАН ДАХЬ БАЙР СУУРЬ

Бид Сайнмэдээний номуудын уран зохиолын төрлийн талаар авч үзлээ. Тиймээс одоо эдгээр нь эрх мэдэл бүхий бичвэр гэдэг үүднээс тэдний чуулган дахь байр суурийг нь авч үзэхэд бэлэн болжээ. Бид эдгээр номуудын чуулганд дахь байр суурийг тэдгээрийн найруулга зүй болон эдгээр нь алдаа мадаггүй Бурханы үг гэдэг байдлаар судлах болно. Эхлээд тэдгээрийн найруулга зүйн талаар харцгаая.

НАЙРУУЛГА ЗҮЙ


Бид Сайнмэдээний Номуудын найруулга зүйн тухай ярихдаа тэдгээрийн хэрхэн бичигдсэн арга замыг санадаг. Тэдний бичээчид нь хэн байсан бэ? Эдгээр номыг тэд яагаад бичсэн бэ? Тэд эдгээр номыг хэрхэн бичсэн бэ? Иймэрхүү асуултуудыг судлах нь Христитгэгчдийн хувьд чухал юм. Учир нь тоо томшгүй олон тайлбарлагчид тухайн номын тэнгэрлэг эрх мэдлийг бууруулахын тулд хүмүүний оролцоо үйл явц дээр нь төвлөрөх гээд байдаг. Сайтар судалж шинжлэх нь эдгээр

Сайнмэдээний Номууд нь хүний гарын бүтээл төдийгүй Бурханы Үг гэдэгт итгэлтэй байхад маань тусалдаг нь сайн хэрэг.

Сайнмэдээний Номуудын найруулга зүйтэй хамааралтай гурван асуудлыг бид авч үзэх болно. Нэгдүгээрт, бид Сайнмэдээний янз бүрийн түүхүүдийн ижил төстэй байдлыг судлах болно. Хоёрдугаарт, бид эдгээр ижил төстэй байдлыг тайлбарлахын тулд бий болсон найруулга зүйн зарим онолыг судлах болно. Гуравдугаарт, бид эдгээр онол нь баталгаатай эсэх талаар зарим нэг тайлбар өгөх болно. Ингээд эхлээд Сайнмэдээний Номуудын ижил төстэй байдлын талаар ярилцаж эхэлцгээе.

Ижил төстэй байдал

Матай, Марк, Лук нар Сайнмэдээний түүхээ тус тусдаа бичсэн боловч тэднийг ихэвчлэн бүлэглэж, Синоптик Сайнмэдээний Номууд гэж нэрлэдэг. “Синоптик” гэдэг нь “хамтад нь харах” гэсэн утгатай нэр томьёо бөгөөд үндсэндээ ижил төстэй мэдээ баримтаар дүүрэн байдаг тул ийнхүү нэрлэдэг. Эдгээр нь Есүсийн үг, үйл хэргийн талаарх ижил төстэй олон түүхүүдийг багтаасан байдаг. Мөн тэд Есүсийн өгүүлсэн нэг утга санааг илэрхийлэхдээ ихэвчлэн яг ижил үгсийг



Синоптик Сайнмэдээний Номууд

ашигладаг.

Жишээ болгон Есүсийн саа өвчтэй хүнийг эдгээсэн талаарх түүхийг авч үзье. Матай 9:6 дээр бид Эзэний үг ба үйлсийн талаар олж хардаг. Энд:

“Тэгвэл Хүний Хүү газар дээр нүглийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд...”, Тэрээр саа өвчтөнд “-Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь” гэжээ (Матай 9:6).

Одоо харин Марк 2:10-11-р эшлэлийг хамтдаа харцгаая. Энд:

“Харин Хүний Хүү газар дээр нүгэл бүрийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд Тэрээр саа өвчтөнд —Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь” гэв (Марк 2:10-11).

Мөн Лук 5:24-р эшлэлийг харвал:

“Харин Хүний Хүү газар дээр нүгэл бүрийг уучлах эрх мэдэлтэйг та

нарт мэдүүлэхийн тулд гээд саа өвчтөнд —Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь” гэжээ (Лук 5:24).


Энэ жишээнээс бид нэг л гайхамшгийн түүхийг бичихдээ Синоптик Сайнмэдээний Номын үг бүр нь бараг л адилхан байгааг харж байна. Гурван Синоптик Сайнмэдээний Номуудын дор хаяж хоёроос нь олдсон үүнтэй адил бусад түүхүүд ч мөн бий. Тухайлбал, уяман өвчтэй хүний эдгэрэл, Капернаумд чөтгөрийг хөөн зайлуулсан түүх, мөн Петрийн хадам эхийн эдгэрэл, далайн шуургыг намжаасан явдал, Иаирын охины амилал, Арван хоёрт эрх мэдлийг даатгасан түүх, Есүс усан дээр алхсан тухай, мөн хатангир гартай эрийн эдгэрэл, таван мянган хүнийг таван талх, хоёр загасаар хооллосон түүх болон Есүсийн дүр төрх хувиран өөрчлөгдсөн зэрэг түүхүүд орно.

Матай, Марк, Лук гэсэн гурван Сайнмэдээний Номууд нь аливаа зүйлсийг ижил төстэй өнцгөөс, өөрөөр хэлбэл нэг нүдний шилээр хардаг учраас тэднийг Синоптик номууд гэж нэрлэдэг. Энэ нь заримдаа ганц нь л хангалттай байхад яагаад гурвын гурав хэрэгтэй гэж гэсэн сэтгэгдэл төрүүлдэг. Синоптик Сайнмэдээний Гурван Номуудын аль нэг нь л байхгүй байвал тун харамсалтай хэрэг болох байв. Яагаад гэвэл эд нар тус бүрдээ өөр өөрийн гэсэн хувь нэмрээ оруулдаг бөгөөд эдгээрийн хоорондын ялгааг олж харах нь зүйтэй юм. Маркийн Сайнмэдээ бол бусад сайн мэдээнүүдээс хамаагүй илүү өнгө будгийг хослуулсан, зарим нэг түүхийг илүү дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг онцлогтой ном юм. Хэдийгээр энэ нь бусдаас илүү богино Номд тооцогддог ч түүхийг илүү дэлгэрүүлэн өгүүлдэг. Харин Матай бол Сайнмэдээндээ илүү их зүйлийг оруулахыг хичээсэн учраас түүхүүдийг илүү товч болгон шахаж багтаасан байдаг. Ялангуяа Матай Есүсийн сургаалыг оруулахыг зорьсон байдаг бол хачирхалтай нь Маркийн Сайнмэдээнд Есүсийн ихэнх сургаалыг хассан байдаг. Тиймээс, Матайн Сайнмэдээнд Есүсийн эрх мэдэл, үг сургаалын талаар ихээхэн өгүүлдэг тул хэрэв та Есүсийн сургаалын нэг төрлийн цомхон эмхэтгэлийг уншихыг хүсэж байвал Матайн Сайнмэдээний Ном бол яг л тэр ном мөн гэж хэлж болно. Тэгвэл Лук бидэнд юу өгсөн бэ? Лук бидэнд бүр их сургаалыг тэмдэглэж үлдээсэн. Тэрээр Матай дээр гардгаас ч илүү олон сургаалт зүйрлэлүүдийг бичиж үлдээсэн. Мөн Есүсийн хүмүүн дүр төрхийг олон байдлаар тусган харуулсан байдаг. Ингэхдээ Тэрээр бүхий л төрлийн хүмүүстэй харилцаж, тэдэнд хайр, халамж үзүүлж буй тухай өгүүлдэг. Зарим хүмүүс Лук нь зөвхөн эмч бус, зарим талаараа сэтгэл зүйч байсан гэж үздэг. Тэр хүний сэтгэл хөдлөлийг маш сайн илэрхийлж чаддаг байв. Дээрх бүгдээс харвал эдгээр Сайнмэдээний гурван Номын хувьд бидэнд маш үнэ цэнтэй, гурван өөр бичвэр байгаа нь илэрхий байна. Тиймээс эдгээрийг бүгдийг нь үнэлж байх ёстой гэж би боддог.

- Доктор Питер Уолкер

Үндсэндээ Есүсийн амьдралын нэг л ижил гэж хэлж болох түүхийг өгүүлэх гурвын гурван Сайнмэдээний ном бидэнд байгаагийн гол шалтгаан бол Есүс хэн бэ гэдгийг ганц номоор илэрхийлэхийн аргагүй баялаг, бас гайхалтай биширмээр байсан явдал гэж би боддог. Тиймээс, бид Бурханы зорьсон зүйлийн талаар бодоход, Есүсийн хийсэн, хэлсэн, гүйцэлдүүлсэн зүйлсийн ач холбогдлыг нэг зохиолч бидэнд хангалттай илэрхийлж чадахгүй. Гэсэн хэдий ч бид Сайнмэдээний гурван номын ялгаатай талуудад тун мэдрэг хандах ёстой гэдгийг нэмж хэлмээр байна. Тийм ээ, тэд үндсэндээ ижил зүйлийг хэлдэг ч тус бүр өөр өөрийн гэсэн өнгө аястай. Тиймээс нэг талаараа тэд Есүсийн юу хийж, юуг гүйцэлдүүлсэн тухай үндсэн түүхийг бидэнд өгүүлэхийн сацуу Есүсийн ялгаатай талуудыг бидэнд харуулдаг. Тэгэхээр энэ нь калейдоскоп буюу гэрлийн дуран авиатай төстэй юм. Бүх зүйлс үүн дотор байх боловч өөр өөр өнцгөөс нь харвал Есүсийн зургийг өөр өөр талаас нь харж буйтай адил байна. Ийнхүү Есүсийг олон талаас нь харах боломжийг олгосон байгаагаас нь бид Ариун Сүнсний онгод буюу Бурханы мэргэн ухааныг харж болдог.

- Доктор Томас Р.Шрайнер



Синоптик Сайнмэдээтэй харьцуулахад Иоханы Сайнмэдээний ихэнх материал их өвөрмөц. Хэдий Иоханы хувьд мөн Есүсийг усан дээр алхаж, таван мянган хүнийг хооллож байсныг дурдсан авч Синоптик Сайнмэдээний номуудад тэмдэглэгдээгүй олон үйл явдлыг багтаасан. Жишээлбэл, Есүсийн усыг дарс болгон хувиргасан тухай, Самари эмэгтэйтэй Есүс ярилцсан тухай, Есүс Лазарыг үхлээс амилуулсан тухай Иохан бичсэн.

Харин Есүсийн үйлчлэл ба амьдралын түүхүүд нь Сайнмэдээний дөрвөн номд харилцан адилгүй байдаг. Гэвч Есүсийн баптисм, сүүлчийн зоог, загалмайн үхэл ба амиллын тухай бүгдээрээ гэрчлэн өгүүлдэг.

Сайнмэдээний Номуудын ижил төстэй болон ялгаатай талууд нь олон маргаантай тайлбарууд руу биднийг хөтөлдөг. Тиймээс одоо Сайнмэдээний Номуудын найруулга зүйн


онолын талаар авч үзэцгээе.

Найруулга зүйн онолууд

Синоптик Сайнмэдээний номуудын хооронд ижил төстэй зүйл олон байдаг

учир эрдэмтэд тэдгээрийн найруулга зүйн түүхийн талаар олон онолыг боловсруулсан. Эдгээр онолууд нь ихэвчлэн нэлээд цогц байдаг бөгөөд бид үүнийг анх судалж эхлэхэд төөрөлдмөөр байж мэднэ. Бид хамгийн түгээмэл онолуудыг дараах байдлаар нэгтгэн харж болох юм. Ихэнх тайлбарлагчид Маркийг анх бичигдсэн гэж итгэдэг төдийгүй Матай, Лук нар Маркаас болон бусад эх сурвалжаас ашигласан гэж үздэг. Гэхдээ бусад тайлбарлагчид Матай ном анх бичигдсэн бөгөөд Марк Матайн материалыг ашигласан ба Лук нь Матай, Марк хоёрын материалыг ашигласан гэж үздэг. Зарим хүмүүс Матай, Лук хоёр хоёулаа бидэнд байхгүй эх сурвалжид үндэслэсэн бөгөөд Марк дээрх хоёрын аль алиных нь материалыг ашигласан гэж үздэг. Таны харж байгаачлан эдгээр онолын ерөнхий шинж чанаруудыг харьцуулах нь хүртэл бага зэрэг төөрөлдүүлмээр байгаа биз.

Эсрэгээрээ Иоханы зохиомж нь нэлээд энгийн. Ихэнх тайлбарлагчид түүнийг нэгдүгээр зууны төгсгөл үед бичсэн бөгөөд дор хаяж нэг, магадгүй бүх синоптик түүхүүдийг мэддэг байсан гэдэгтэй нь санал нийлдэг. Тэрээр Синоптикт аль хэдийн



Иохан хамгийн багадаа нэг, эсвэл магадгүй бүх синоптик түүхүүдийг мэддэг байсан.

дурдсан байсан ихэнх материалыг давтахаас зайлсхийж, үйлчилж байсан талбартаа хамгийн их хамааралтай ач холбогдолтой байсан нэмэлт мэдээллийг өгсөн байна гэж үздэг.

Ингээд найруулга зүйн эдгээр онолуудыг харгалзан үзсэн тулд одоо бүгдээрээ эргэлзээгүй баримтлах ёстой зүйлсийн талаар ярилцацгаая.

Баталгаатай байдал

Юуны түрүүнд библийн бичээчид аман болон бичгийн уламжлалуудыг байнга ашигладаг байсан бөгөөд эдгээр нь бичвэрүүдийн онгод ба эрх мэдлийг

алдагдуулдаггүй байсныг бид ойлгох ёстой. Тиймээс Сайнмэдээний бичээчдийн хэн нь ч бай өмнө байсан эх сурвалжид тулгуурласан гэдэгт итгэх нь зарчмын хувьд буруу зүйл биш юм. Энэ талаар Лук 1:1-3 дээр өгүүлдэг. Энд:

“Бидний дунд биелсэн үйл явдлуудын тухай хүүрнэлийг олон хүн эмхэтгэхийг хичээсэн билээ. Анхнаас нь нүдээр үзсэн гэрчлэгчид хийгээд үгийн үйлчлэгч бологсдоос бидэнд уламжилсны адил би ч бас энэ бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд дэс дараалан бичиж өгөх нь зүйтэй юм” гэжээ (Лук 1:1-3).

Сайнмэдээний бусад бүх бичээчид Лукийн өгүүлсэн шиг маш тодорхой илэрхийлээгүй авч ижил төстэй эх сурвалжуудтай холбоотой байсан бололтой. Хэрэв бид ихэнх тайлбарлагчид шиг Маркийг хамгийн түрүүнд бичсэн гэж таамаглавал түүний хувьд өмнө нь бичигдсэн Сайнмэдээг олж авах боломжгүй учраас гарцаагүй аман уламжлалуудыг ашигласан, эсвэл дор хаяж дотнын найз Петрээс мэдсэн биз. Лук, Матай хоёр Маркийн Сайнмэдээг загвар болгон ашигласан байж магадгүй. Үүнээс гадна Матай, Иохан нар Есүсийн амьдрал, сургаалын тухай өөрийн гэсэн туршлага дурсамжтай байсан. Өмнө дурдсанчлан дөрвөн бичээчид бүгд Ариун Сүнсээр алдаа мадаггүй удирдуулсан байдаг.

Дүгнэж хэлэхэд бид Сайнмэдээний номуудын хоорондын харилцааны талаарх онолуудын ач холбогдлыг ойлгож үнэлж болно. Гэхдээ бид тэдний бүх нарийн ширийн зүйлийг ойлгох эсвэл аль нэг онолыг нь тууштай хатуу баримтлах ёстой гэж бодох ёсгүй. Эдгээр онолууд нь Сайнмэдээний бичээчид олон эх сурвалжаас мэдээлэл авч, Есүсийн амьдрал, сургаалын талаар найдвартай түүхийг бүтээх чадвартай байсан гэдэгт итгэлтэй байхад чиглүүлдэг. Тэдний тэмдэглэлд давхацсан зүйл байгааг олж харахдаа хэн нь ч түрүүлж бичсэн бай тухайн Сайнмэдээний бичээчдийн өөр өөр өнцгүүдийг харах боломж бидэнд байдаг. Мөн бид Сайнмэдээний номуудын аль нэгэнд нь л гардаг зүйлийг уншихдаа тухайн бичээчийн онцгой зорилгын үүднээс судлах боломжтой.

Сайнмэдээний дөрвөн номын найруулга зүйн талаар авч үзсэн тул одоо бид тэднийг алдаа мадаггүй эсэхийг авч үзэхэд бэлэн боллоо.

АЛДАА МАДАГГҮЙ БАЙДАЛ

Анхны зууны сүм чуулганы үед элч нарын үеийн чухам аль номууд нь үнэхээр Шинэ Гэрээнд хамаарах талаар зарим санал зөрөлдөөн гарч байв. Эртний чуулганы зарим удирдагчид Шинэ Гэрээнд одоо байгаа бүх номыг хүлээн зөвшөөрдөггүй байв. Бусад нь одоо байгаа хорин долоон номоос гадна нэмэлт ном оруулах ёстой гэж үздэг байв.

Гэвч эдгээр маргаанд Матай, Марк, Лук, Иохан нарын талаар ер дурдагдаагүй. Бурханы итгэмжит чуулганууд Сайнмэдээний эдгээр дөрвөн номыг үргэлж л жинхэнэ, эрх мэдэлтэй номууд хэмээн хүлээн авдаг байжээ.

Жишээлбэл, МЭ 185-254 он хүртэл амьдарч байсан III зууны чуулганы эцэг Ориген одоо бидэнд буй Шинэ Гэрээнд байгаа Сайнмэдээний дөрвөн номыг л жинхэнэ баттай гэж маргаж байлаа. МЭ 263-340 оны хооронд амьдарч байсан



Ориген

Нэмж дурдахад, үүнээс зуун жилийн өмнө буюу МЭ 130 - 202 онд амьдарч байсан чуулганы эцэг Иренаус *"Тэрсүүдийн Эсрэг"* бүтээлийнхээ 3-р номын 11-р бүлгийн 8-р хэсэгт дөрвөн талт Сайнмэдээний номуудын талаар нэг ижил зүйлсийг өгүүлдэг. Түүний бичсэн зүйлийг сонсоцгооё. Энд тэрээр:

Сайнмэдээний Номууд нь тооны хувьд одоогийнхоос илүү олон эсвэл цөөн байх боломжгүй... Хүмүүст илчлэгдсэн Есүс Тэрээр бидэнд Сайнмэдээний дөрвөн онцгийг өгсөн. Гэвч эдгээр нь хамтдаа нэг Сүнсээр холбогдсон билээ гэсэн байна.



Ирениус

Иренаус энэ дөрвийн аль нэг нь маргаантай байсан, эсвэл чуулганы мөргөлд эдгээр дөрвөөс өөр Сайнмэдээг ашиглаж байсныг мэдэхгүй юм байна гэж хэлжээ.

Найдвартай бичээчид

Сайнмэдээний эдгээр дөрвөн номд анхны чуулган итгэл төгс байсан дор хаяж гурван шалтгаан бий. Нэгдүгээрт, өөрсдийнхөө нэрээр нэрлэсэн найдвартай бичээчид бичсэн учраас чуулган Сайнмэдээний номуудыг найдвартай гэж хүлээн авсан. Сайнмэдээний номууд анхандаа тодорхой нэргүй бичигдсэн байх магадлалтай. Гэхдээ тэдгээрийг анх хэвлэгдэх үед бичээчдийг нь таньдаг хүмүүс хүлээж авсан гэж харагддаг. Эсвэл бүр бичээчийн нэрийг тодорхой бичиж тараасан ч байх магадлалтай. Эрт дээр үеэс Христитгэгчдийн бичвэрүүдэд Сайнмэдээний Номуудыг Матай, Марк, Лук, Иохан гэдэг нэрстэй холбож бичсэн байдаг. Тэдгээр дөрвөн хүн бол Шинэ Гэрээнд нэр хүндтэй чуулганы удирдагчид гэдгээрээ танигдсан хүмүүс байлаа.

Элчит баталгаа

Хоёрдугаарт, эдгээр номууд нь элч нараар батлагдсан гэдэг үндэслэлээр эртний Христитгэгчид мөн л Сайнмэдээний Номуудын канон дахь байр сууринд итгэлтэй байсан. Матай, Иохан нар Есүсийн үг ба үйл хэргийг нүдээр үзэж гэрчилсэн элч нар байв. Марк бичсэн зүйлсийнхээ ихэнхийг Петрээс авсан байх гэж үздэг. 1



Евсебиус

Петр 5:13 дээр Петр Маркийг “миний хүү” хэмээн энхрийлэн бичсэн нь бий. Бидний хэдийнээ үзсэнчлэн Лук 1:1-4 дээр Лук өөрийн ажлыг нүдээр гэрчлэгсдийн ярианд үндэслэсэн гэдгээ тайлбарласан.

Түүгээр ч барахгүй Еусебий *Чуулганы түүх* номдоо элч Иохан нь бусад гурван Сайнмэдээний номууд нь өөрийнхөөс нь өмнө бичигдсэн гэдгийг биечлэн баталсан байдаг гэжээ. Элч Иоханы тухай бүтээлийнхээ 3-р номын 24-р бүлгийн 7-р хэсэгт Еусебий юу гэж бичсэнийг харцгаая. Энд:

Матай, Марк, Лук нар бүгдийн гарт болон түүний өөрийнх нь гарт очсон бөгөөд тэрээр тэднийг хүлээн зөвшөөрч, тэдний үнэн байсныг гэрчилсэн гэж Гурван сайнмэдээний ном аль хэдийн дурдсан.

Чуулганы Гэрчлэл

Гуравдугаарт, 1-р зууны чуулганы гэрчлэл нь Сайнмэдээний дөрвөн Номыг дэмждэг. Дөрвөн ном бүгд Есүсийн амьдрал, үйлчлэлийг нүдээр гэрчлэгсэд нь тэдгээрт буй түүхийг үгүйсгэх эсвэл батлах хэмжээний хангалттай он цагийг элээсэн. Нүдээр гэрчлэгсэд нь эдгээр номуудыг чуулганд маш эрт хүлээн авснаараа үүнийг баталсан байдаг.

Бурхан Өөрийн Үгэнд Өөрийн дуу хоолойг батлан гэрчилдэг. Гэвч бид Бичвэрт дурдагдсан түүхэн үйл явдлуудыг харж болох бөгөөд тэдгээр нь түүхийн талаар бусад эх сурвалжаас олж авсан бидний мэдлэгтэй уялдаж байдаг нь тун тустай. Библид нийгмийн болоод улс төрийн нөхцөл байдал, газарзүй болон бусад бүх төрлийн зүйлс дурдагдсан байдаг. Эдгээр нь бидний мэдэх түүхийн цаг хугацаатай, тэр дундаа Сайнмэдээний Номууд бичигдсэн нэгдүгээр зууны үеийнхтэй нийцэж байдаг. Гэсэн хэдий ч, бид Библи дэх түүхэн тодорхой зүйлс болон тэдгээрийн талаарх түүхэн нөхцөл байдлыг харвал эдгээр нь яг л болно гэсэн цагтаа ариун сүнсний гэрчлэлийн хамт болсон нь хангалттай үндэслэл болж өгдөг. Тийнхүү бид эдгээрийг Бурханы үг мөн гэсэн бүрэн дүүрэн итгэлийг олж авдаг. Тиймээс бидний мэдэх каноны дөрвөн Сайнмэдээ болох Сайнмэдээний эдгээр номуудыг элч нараас буюу элчит эх сурвалжаас эхтэй гэж хүлээн авдаг. Мөн Есүсийн хэн байсан, юу хийсэн, юу заасан зэргийг нүдээр үзэгсдийн итгэж болохуйц, үнэн баттай гэрчлэл гэж үздэг.

- Пастор Майкл Ж.Глодо

Сайнмэдээний Номуудыг найдвартай, онгод оруулагдсан, бодит баримтад үндэслэсэн гээд шууд хэлэх олон шалтгаан бий. Гэхдээ магадгүй миний хэлж чадах хамгийн чухал нь бол нүдэн гэрчүүд өөрсдийн гэрчлэлээ амь, амьдралаараа тамгалсан явдал юм. Тэдний нэг нь ташуурдуулж, зодуулж, шоронд хаягдан, загалмайд цовдлогдохоос өмнө бодохдоо “Өө энэ чинь зүгээр л нэг түүх шүү дээ” гэж хэлнэ гэж бодох байх. Тэд хэлсэн зүйлийнхээ төлөө үхсэн. Мэдээжийн хэрэг, хүмүүс худал хуурмаг зүйлсийн төлөө үхэхэд бэлэн байдаг нь тун элбэг байсан гэдгийг бид бүгд мэднэ. Худал хуурмагийн төлөө ийнхүү үхэж буй хүмүүсийн дийлэнх нь тэдгээрийг худал гэдгийг мэддэггүй. Хэрэв энэ худал нь тэднийг амьдралынх нь туршид асар их эрх мэдэл, эд баялаг, нэр хүндтэй болгосон бол тэд худал гэдгийг мэддэг хэдий ч үхэж магадгүй юм. Гэхдээ тун цөөхөн байх нь ойлгомжтой. Харин Сайнмэдээний бичээчдийн алинд нь ч ийм зүйлс байсангүй. Тэд энэ дэлхийд хэн ч биш байсан. Тэд үргэлж зугтаж, үгүйрэн хоосорч, золиос болж, зодуулж, дараа нь үхэцгээсэн юм. Тийм боловч тэдний хэн нь ч гэрчлэлээсээ буцсангүй. Тийм учраас бид эдгээр нь үнэн бодитой гэдэгт баттай итгэж болдог.

- Доктор Дан Дориани


Ингээд бид Сайнмэдээний Номуудын уран зохиолын төрлийг судалж, чуулган дахь тэдний байр суурийг харлаа. Одоо Шинэ Гэрээний Сайнмэдээний эдгээр дөрвөн номын нэгдмэл байдлын талаар үзэхэд бэлэн боллоо.

НЭГДМЭЛ БАЙДАЛ


Бид Сайнмэдээний Номуудын нэгдмэл байдлын талаар авч үзэхдээ нэгдүгээрт, ном бүр нь Бурханы хаанчлалын талаар нэг ижил түүхийг өгүүлдэг болохыг харна. Хоёрдугаарт, тэдгээр нь бүгд Бурханы хаанчлалыг авчирч буй Есүсийг онцолсон болохыг судална. Тэгэхээр эхлээд Шинэ Гэрээний Сайнмэдээний Ном тус бүр нь бүгдийг хамарсан нэг ижил түүхтэй холбогдсон байдаг гэдгийг авч үзэцгээе.

Нэг ижил түүх


Матай




Марк



Лук



Иохан



Дөрвөн ном бүгд нэг л ижил Сайнмэдээний түүхийг буюу Есүсийн "Сайнмэдээ"-г өгүүлдэг.

Матай, Марк, Лук, Иохан нарын номонд өгүүлсэн түүхийг ерөнхийд нь Сайнмэдээ гэж хэлж болно. Чухамдаа ийм учраас л номуудыг өөрсдийг нь "Сайнмэдээний Номууд" гэж нэрлэсэн. Эдгээр нь Сайнмэдээний түүхийг өгүүлдэг номууд гэсэн үг. Тэгвэл Сайнмэдээний түүх гэж чухам яг юу вэ?

"Сайнмэдээ" гэдэг үг нь Грек хэлний *евангелион* (εὐαγγέλιον) гэсэн үгийн орчуулга бөгөөд энгийнээр "сайхан мэдээ" гэсэн утгатай. Тиймээс Библид Есүсийн Сайнмэдээний тухай ярихдаа Есүсийн талаарх сайхан мэдээ гэж илэрхийлдэг. Гэхдээ яахлаараа энэ нь сайхан мэдээ болох вэ? Есүс гэж хэн юм бэ? Сайнмэдээний Номууд нь Есүсийн тухай ямар түүх өгүүлдэг вэ?

Эдгээр асуултад хариулахын тулд бид "Сайнмэдээ" гэдэг үг заримдаа эртний ертөнцөд маш тодорхой төрлийн мэдээг хэлдэг гэдгийг ойлгох хэрэгтэй. Тодруулбал, дайчин хаад эсвэл эзэн хаад шинэ газар нутгийг эзлэн авч, ялалтаа зарлан тунхаглахдаа ийнхүү "сайхан мэдээ" гэж нэрлэдэг байв. Энэхүү "Сайнмэдээ" буюу "сайхан мэдээ" гэдэг нь хааны ялалтын тунхаг байсан бөгөөд түүний хаанчлал нь ард түмэндээ ивээл ерөөлийг авчрах болно гэсэн утгыг агуулдаг байв. Үнэн хэрэгтээ энэ нэр томъёог Хуучин Гэрээнд заримдаа яг ингэж ашигладаг байсан. Жишээлбэл, Исаиа 52:7 эшлэлд энэ тухай өгүүлдэг. Энд:

“Амар тайвныг сонордуулж, Сайн сайхныг мэдээлж Авралыг сонсгож, Сионд хандан “Чиний Бурхан хаанчлах нь ээ” гэж хэлэх Сайнмэдээ авчрагчийн хөл Уулсын дээр юутай үзэсгэлэнтэй вэ?” гэжээ (Исаиа 52:7).

Энэ эшлэлд Исаиа Иерусалимыг хүрээлэх уулан дээр буй элч нар Израилын цөллөгийн хугацаа дууссан тухай сайн сайхан мэдээг тунхаглаж байгааг үзлээ. Бурхан бүхнийг хаанчилдаг учир амар амгалан, авралыг тэд зарлан тунхаглажээ.

Исаиагийн эш үзүүлэгийн үеийн нөхцөл байдлыг харвал Бурханы хаанчлал буюу дэлхий дээр Түүний хаанчлал байгуулагдах нь Израил болон Иудагийн ард түмний сонсох ёстой сайхан мэдээ байсан юм. Энэ нь Бурханы хаанчлалын дор тэд дайснуудаас чөлөөлөгдөж, Бурханы дэлхий даяарх хаант улсад үүрд амьдрах болно гэсэн мэдээ байв.

Гэвч Исаиагийн өдрүүдэд Бурхан үүнийг хараахан хийгээгүй байсан. Исаиагийн эш үзүүлэг нь ирээдүйд Бурхан бүх дэлхийг захирах хааны эрх мэдлээр ирэх өдрийг тэсэн ядан хүлээж байв. Матай, Марк, Лук, Иохан нарын хэлсэн сайхан мэдээ бол тэрхүү хүсэн хүлээсэн өдөр нь Есүс дотор эцсийн байдлаар биелсэн

гэдгийг өгүүлдэг. Сайнмэдээний бичээчид бүгд Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийг биелүүлж, Бурханы хаанчлалыг авчирсан нэгэн бол Есүс мөн хэмээн заах нэг ижил түүхийг өгүүлсэн. Тэд бол цор ганц хаан болох Есүсээр дамжуулан Бурханы хаанчлал дэлхийд ирсэн талаарх сайхан мэдээг тунхагласан үзэсгэлэнтэй хөлтэй элч нар байсан. Хаанчлал ирж буй тухай энэхүү нэг ижил түүх нь Сайнмэдээний дөрвөн Номуудад байдаг ерөнхий нэгдмэл байдлыг бий болгодог.

Энэ баримтаас үзвэл Шинэ Гэрээний Сайнмэдээний номууд нь “сайнмэдээ” болон “сайн мэдээг тараах” гэсэн нэр томъёог Бурханы хаанчлал гэдгийг тодорхойлсон хэллэгүүдээс хамаагүй бага ашигласан байдагт гайхах зүйлгүй. Матай, Марк, Лук, Иохан номын турш "сайнмэдээ" гэдэг үгийн янз бүрийн хэлбэрүүд нийтдээ 23 эшлэлд л дурдагдсан байдаг. Харин эсрэгээрээ "хаан", "Бурханы хаанчлал" гэх мэт хэллэгүүд болон Матай ном дахь "тэнгэрийн хаанчлал" гэсэн онцгой нэр томъёо нь 150 орчим удаа гардаг.

Ингээд бид Сайнмэдээний бүх Номууд Бурханы хаанчлалын талаарх нэг л ижил түүхийг өгүүлдэг гэдгийг ойлголоо. Тиймээс одоо Есүсийг Бурханы хаанчлалыг авчирсан хаан хэмээн онцолсныг хамтдаа харцгаая.

ЕСҮС

Есүс болон хаанчлалын талаар бидний энэхүү яриа гурван хэсэгт хуваагдана. Нэгдүгээрт, Есүс хаанчлалыг авчирсан гэдгийг харуулах Сайнмэдээний Номуудад буй зарим нотолгоог авч үзнэ. Хоёрдугаарт, Есүс болон хаанчлалын тухай ярихдаа ашигладаг Библийн үгсийг тайлбарлах болно. Гуравдугаарт, Есүс хаанчлалыг үе шаттайгаар авчрах болно гэдгийг бид харна. Тэгэхээр эхлээд Есүс хаанчлалыг авчирсан гэдэг талаарх зарим нотолгоонуудыг авч үзэцгээе.

Нотолгоонууд

Сайнмэдээний Номууд нь Бурханы хаанчлал Есүсээр дамжуулан ирсэн болохыг олон янзаар баталсан байдаг. Гэхдээ хичээлийнхээ зорилгын дагуу бид зөвхөн гуравт нь л анхаарлаа хандуулах болно. Нэгдүгээрт, Бурханы хаанчлалын нотолгоо болгон бид чөтгөрүүдийн дээгүүрх Есүсийн эрх мэдлийг авч үзэх болно. Матай 12:28-р эшлэлд Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

“Харин Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймээс Бурханы хаанчлал та нар дээр ирчхээд байна” гэжээ (Матай 12:28).

Энэ багц хэсэгт Есүс чөтгөрийг хөөн зайлуулсан. Тэрээр чөтгөрүүдийг хөөн зайлуулж байгаа нь Тэрээр Бурханы хаанчлалыг авчирсан гэдгийг баталдаг.

Хоёрдугаарт, эдгээр номууд нь Бурханы хаанчлал ирсэн гэдгийг өвчтэй хүмүүсийг эдгээж, үхэгсдийг амилуулах хүч Есүст байсан гэдгээс харж болдог.

Есүсийн эдгээх хүч, мөн дагалдагч нартаа өгсөн тэрхүү хүч нь Бурханы хаанчлалыг Тэрээр авчирсан гэдгийг нотолдог. Бид энэ сэдвийг Матай 4:23-24, 8:5-13, 10:7-8 зэрэг эшлэлүүдээс хардаг. Бид мөн үүнийг Лук 9:1-11, 10:9 болон бусад

олон хэсгээс харж болно. Хаанчлал ирж буй нь Есүсийн нүглийг уучлах эрх мэдлээс мөн харагддаг.

Исаиа 33:22-24 дээр Исаиа ирэх Мессиагийн талаар юу гэж зөгнөснийг харцгаая. Энд:

“Учир нь ЭЗЭН бол шүүгч маань, ЭЗЭН бол хууль тогтоогч минь, ЭЗЭН бол хаан маань юм. Тэр л биднийг аварна ... “Би өвчтэй байна” гэж Нэг ч оршин суугч эс өгүүлнэ. Тэнд амьдарч байгаа хүмүүсийн Хилэнц нүгэл уучлагдах болно” гэжээ (Исаиа 33:22-24).

Исаиа энд эдгээж, уучлах эрх нь зөвхөн хаан болох Бурханд байдаг гэдгийг хэлсэн. Тэгээд тэрээр Мессиа дэлхий дээр Бурханы хаанчлалыг сэргээх үед эдгэрэлт, уучлал нь эцэстээ Мессиагаар дамжин ирнэ хэмээн эш үзүүлжээ.

Энэ бол яг л Есүсийн хийсэн зүйл мөн. Тэрбээр хүмүүсийг Бурханы хаанчлалд орохыг уриалсан. Тэр тэдэнд үхлийн оронд амь амьдралыг санал болгосон. Энэ бол нүглээс ангижрах мэдээ, авралын мэдээ байв. Есүс энэ талаар Марк 2:9-11 дээр өгүүлсэн нь бий. Энд:

“Саа өвчтөнд “Нүгэл чинь уучлагдсан” гэж хэлэх эсвэл “Бос, дэвсгэрээ аваад яв” гэж хэлэхийн аль нь амархан бэ? Харин Хүний Хүү газар дээр нүгэл бүрийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд Тэрээр саа өвчтөнд — Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь” гэжээ (Марк 2:9-11).

Хаанчлалыг тээж буй Хүний Хүүгийн хувьд дэлхий дээр нүглийг уучлах эрх мэдэлтэй гэдгээ зарласнаар Есүс хүн бүрийг гайхшируулсан. Есүс дотор Бурханы засаглал ирчхээд байна. Бурханы захиргаа, Бурханы *хаанчлал* энэ дэлхийд одоо ирчихсэн. Энэ бол Бурханы ард түмэндээ зориулсан ивээл ерөөл гэсэн үг юм. Энэ нь Исаиагаар дамжуулан олон жилийн өмнөөс эш үзүүлж байсан Бурханы амар амгалан эцэст нь ирсэн гэсэн үг билээ.

Дээрх нотолгоог харгалзан эдгээр номуудын Есүс болон хаанчлалын тухай ярихдаа ашигласан үгсийн сангийн талаар ярилцъя.

Үгсийн сан

Христитгэгчид заримдаа Сайнмэдээний Номуудаас Бурханы хаанчлалыг онцолсныг шууд анзаардаггүйн нэг шалтгаан нь Сайнмэдээний бичээчид энэ талаар бичихдээ маш олон янзын үг ашигласантай холбоотой. Тэд “хаан”, “хаанчлал” гэх мэт үгсийг ашигласан нь ойлгомжтой байдаг. Гэхдээ тэд мөн "захиргаа", "засаглал", "эрх мэдэл", "сэнтний", "Давидын Хүү" гэх мэт Бурханы дээд эрх мэдэл, удирдлагыг заасан бусад олон үгсийг ашигласан.

Шинэ Гэрээний бичээчид Бурханы хаанчлалын тухай ярихдаа янз бүрийн үгсийг ашигласан байдаг бөгөөд зөвхөн тодорхой үгсийг төдийгүй холбоотой ойлголтуудыг ч мөн ашигладаг. Жишээлбэл,

"Мессиа" буюу "Тослогдсон Нэгэн" гэсэн утгатай *Христос* гэсэн Есүсийн нэр нь Хуучин Гэрээнд Давидын Хүү болох хааны тухай өгүүлдэг хэллэг юм. Эсвэл бид мөн Есүсийг Цезарьтай адил хаан болохыг илтгэх *куриос* буюу Эзэн хэмээсэн байдгийг харж болно. Цезарийг ч мөн куриос буюу эзэн гэдэг байсан юм. Тиймээс Шинэ Гэрээний бичээчдийн цаг хугацаа, нөхцөл байдалд "Эзэн" гэх үгийн эрх мэдлийг хүмүүс ойлгож байсан. Мэдээж хэрэг, бидэнд байгаа хамгийн чухал хэллэг бол "Бурханы хаанчлал" буюу Матай ном дахь "Тэнгэрийн хаанчлал" гэсэн хэлц юм. Тэгэхээр энэ хэлцийг хоёр янзаар ярьж болдог. Нэг нь Христ Өөрийнхөө ард түмнийг захирч буй тодорхой засаг захиргааны тухай байна. Гэвч энэ нь Бурханы захиргаа буюу ард түмнээ захирч буй Бурханы эрх мэдлийн талаарх үгэнд хамаарах ойлголт юм. Тиймээс жишээ нь, үүнтэй холбоотой дараагийн нэг ойлголт бол дуулгавартай байдлын талаарх ойлголт юм. Энэ нь Бурханы хаанчлал гэх томъёонд шууд хамааралтай харагддаггүй л дээ. Хэдий тийм ч энэ нь хааны эрх мэдэл, түүнд дуулгавартай байх, тэр ч байтугай Есүстэй харилцаатай байхаар дууддаг мөргөл хүндлэлийн ойлголттой ч шууд холбоотой байдаг.

- Доктор Грегори Р.Пэрри

Зөвхөн нэг жишээ дурдахад, Марк 2:1-12-р эшлэлд Есүс саа өвчтэй хүнийг эдгээсэн түүхэнд "хаан" эсвэл "хаанчлал" гэсэн үгс байдаггүй. Гэсэн хэдий ч 10-р эшлэлд Есүс "Хүний Хүү газар дээр нүгэл бүрийг уучлах эрх мэдэлтэй" гэснээр түүх бүхэлдээ хаанчлалын утгатай болохыг олж харахад хүргэдэг. Бурханы хаанчлал нь Есүсийн хүчирхэг эдгээх үйлс ба өршөөлийн үгсээр энэ дэлхийд ирсэн. Үнэн хэрэгтээ Бурханы хаанчлалын сүр жавхлантай, ивээл ерөөлтэй шинжийг дүрсэлсэн Хуучин Гэрээний эш үзүүлэлтийн зураглалын цаана Есүсийн хийсэн эдгээр сайн зүйлс нь нэг талаар Бурханы хаанчлалын амталгаа байсан.

Бурханы хаанчлалын талаарх Хуучин Гэрээний хүлээлт ба найдвар нь, ялангуяа Исаиагийн Номд өгүүлснээр Бурхан Өөрийн хаанчлалыг байгуулахаар заларч, захирахаар ирнэ гэсэн тэрхүү найдвар нь чухамдаа бүх зүйл зөв болж, сэргэх тэрхүү цагийн төлөөх найдвар байсан юм аа. Тийм болохоор Есүсийн үйлчлэл болон Сайнмэдээний Номууд нь өөрөө Түүний эдгэрэл, босгон байгуулалтын үйлчлэлүүд байсан. Тэрээр үхэгсдийг амилуулж, цус алдалтыг зогсоож, хугарсан ясыг бүтэн болгон, сохрыг хараа оруулсан. Эдгээр нь зөвхөн Есүсийн хүч чадал, эрх мэдлийг өмгөөлөн баталгаажуулсан хэрэг биш байв. Мөн зөвхөн Бурханы хүч чадлын илэрхийлэл төдий ч биш. Харин үнэндээ Бурханы засаглал буюу Түүний сэргээн шинэчлэх захиргаа ба хаанчлал нь Христ дотор ирж буй бөгөөд хэдийнээ ирчихсэн гэсэн утгатай. Тиймээс энэ бол Бурханы хаанчлалын талаарх хэллэгээс гадна Бурханы хаанчлал хэрхэн ажиллаж буйг харж болох олон арга


замуудын нэг билээ.

- Доктор Жонатан Т.Пеннингтон

Бид Есүс Бурханы хаанчлалыг авчирсан тухай зарим нотолгоог харж, Есүсийн хаанчлалын талаар өгүүлэхдээ ашигласан үгсийн тухай авч үзлээ. Харин одоо Есүс хаанчлалыг авчирсан үе шатуудын тухай товч тайлбарлая.

Үе шатууд

Түүний өгүүлж буй хаанчлалын өнөөгийн бодит байдал нь бүрэн бүтэн дүр зураг биш гэдгийг Есүс заасан. Хаанчлалын өөр нэг үе шат нь хараахан ирээгүй байна. Ирээдүйд хэзээ нэгэн цагт Бурханы хаанчлал бүрэн дүүрэн биеллээ олох болно.



Есүс хаанчлалыг гурван үе шаттайгаар авчирсан.

Лук 21:27-28 дээр Есүс ирээдүйн энэ өдрийг дүрсэлсэн байна. Энд:

“Тэгээд тэд Хүний Хүүг үүлэн дунд аугаа сүр хүч, цог жавхлантайгаар ирэхийг харна. Харин эдгээр нь биелж эхлэх үед цэх зогсож тэргүүнээ өргө. Учир нь та нарын золилт айсуй” гэжээ (Лук 21:27-28).

Олон Еврей теологичид Мессиа ирэхдээ нүгэл ба үхлийн энэхүү хуучин эринийг нэг дор устгаж, Бурханы хаанчлалын шинэ эрин үеэр солино гэж Хуучин гэрээ заасан хэмээн тайлбарладаг байв. Гэвч Есүс хаанчлалыг үе шаттайгаар авчирч байгаагаа хэлсэн. Тэрээр газар дээрх үйлчлэлээрээ хаанчлалыг эхлүүлсэн. Түүний тэнгэрээс захирч буй одоо үед хаанчлал нь үргэлжилж байна. Тэгээд Түүнийг буцаж ирэх үед энэ нь бүрэн төгс болох болно.

Апокалиптик буюу ертөнцийн төгсгөлийн талаарх Иудейн үзэл санаа нь бүх бодит байдлыг хоёр цаг үед хуваасан байдаг. Эдгээр нь өнөөгийн бузар муу цаг үе ба ирэх үе юм. Энэ нь Бурхан эцсийн үеийн хаанчлал буюу ирэх үеийг авчрахдаа гэнэтийн, аймшигтай байх ба гарцаагүй тохиолдоно гэж хүлээдэг. Та хаанчлалын өмнөх үеэс хаанчлалын цаг хугацаа рүү буюу хаанчлалын үе рүү шууд л шилжинэ гэж үздэг. Харин Шинэ Гэрээнд эцсийн үеийн уртасгалт гэж миний нэрлээд байгаа ойлголт байдаг. Тиймээс апокалиптик иудейн үзэл санаанд дүрслэгдсэн шиг хаанчлалын үеийг одоо "аль хэдийн" ирсэн тэнгэрийн хаанчлал, мөн "хараахан ирээгүй" тэнгэрийн хаанчлал гэсэн хоёр үе болгон хуваадаг.

- Доктор Дэвид Р.Бауэр

Бид Бурханы хаанчлалын тухай ярих үедээ энэ тухай ихэвчлэн "ирчихсэн" гэж ярьдаг боловч үнэн хэрэгтээ бид ирээдүйд ирэх хаанчлалыг хүсэн хүлээсээр л байдаг. Гэтэл Есүс бидэнд "Таны хаанчлал ирэх болтугай" хэмээн залбирахыг заасан шүү дээ. Мөн Хаан ирчихсэн учраас энэ дэлхий дээр Тэрээр хаанчлалаа эхлүүлчихсэн гэсэн утгатай байдаг. Гэвч бид Түүнийг эргэж ирэхийг хүлээсээр л байна. Христийн хоёр дахь ирэлт нь Есүсийн анхны ирэлтээр хийсэн зүйлийн бүх ашиг тус, утга учир нь эцэстээ бүрэн биеллээ олох өдөр байх болно. Энэ нь мөн итгэгч бүр Сайнмэдээг ярихдаа хааны ирээдүйн ирэлтийн тухай тунхаглах үүрэгтэй гэсэн үг юм. Тиймээс бид хүмүүсийг Христ эргэн ирэх өдөрт бэлэн байхыг уриалдаг. Гэсэн ч бид итгэгч болохынхоо хувьд одоо Христийг өөрийн Эзэн болгон хүлээн авсандаа баярлан талархдаг. Тиймээс одоо бид Түүний засаглал дор амьдарч байгаа ч энэхүү засаглалыг бүрэн дүүрэн биелэх өдрийг зөвхөн бид өөрсдөө төдийгүй, бүх бүтээлүүд ч хүсэн хүлээж байна.

— Пастор доктор Саймон Виберт

Нэгдүгээр зууны ихэнх иудей хүмүүс Есүсээс нүүр буруулсан нь гайхах зүйл биш. Яагаад гэвэл Түүний дүрсэлсэн хаанчлал нь тэдний хүсэн хүлээж байсан хаанчлал шиг харагдахгүй байв. Тэд Ромыг унагаж, иудейчүүдийг Ромын дарлалаас чөлөөлөх хаан буюу хаанчлалыг хүлээж байлаа. Есүс ийм төрлийн хаан байх сонирхолгүйгээ илэрхийлэх үед олон хүн нүүр буруулж, холдсоныг бид Лук 17:20-25, Иохан 6:60-69-р эшлэлүүдээс харж болдог.

Мэдээж ийнхүү татгалзсан нь эцэстээ Есүсийг цаазаар авхуулахад хүргэсэн. Есүсийн загалмайн үхэл нь Түүний хаанчлалын эсрэг дайсагналын үр дүн хэр нь Түүний хаанчлалын ялалтын тэмдэг байсан нь Сайнмэдээний агуу егөөдөл гэлтэй. Түүний амилал ба тэнгэр өөд одсон явдал нь Бурхан Эцэгийн баруун гарт байх хааны сэнтийд хүрэх зам байв. Лукийн Үйлс 1:3 дээр дурдсанчлан Есүс амилаад тэнгэр өөд одох хүртэлх дөчин хоногийг шавь нартаа Бурханы хаанчлалын тухай заахдаа

зориулсан нь ийм учиртай.

Матай 28:18 дээр Есүс тэнгэр өөд одохынхоо өмнөхөн энэ тухай өгүүлсэн нь бий. Энд:

“Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” гэжээ (Матай 28:18).

Бурханы хаанчлалын талаарх сэдэв бол Сайнмэдээний Номууд дахь Есүсийн амьдралын үйл явдлуудыг хооронд нь холбосон тэрхүү сайхан мэдээ мөн. Сайнмэдээний Номууд нь Бурханы хаанчлал Есүсээр ирнэ гэх Өөрийн амлалтаа Бурхан биелүүлсэн гэх сайхан мэдээг тунхагладаг. Есүсийн ялгуусан ялалтын амьдрал нь нэгэн өдөр Тэрээр хаанчлалаа төгсгөхөөр эргэн ирж, Түүгээрээ бүх ерөөлүүдийг бүрэн дүүрэн авчрах болно гэдгийг бидэнд баталдаг.

ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Энэ хичээлээр бид Сайнмэдээний номуудын уран зохиолын төрөл, чуулган дахь байр суурь болоод нэгдмэл байдлыг нь авч хэлэлцлээ. Тэгэхээр одоо бид тэдний бие биеэс нь өөр болгож буй ялгаатай байдлынх нь талаар ярилцахад бэлэн болжээ.

Бидний харсанчлан Сайнмэдээний дөрвөн номууд бүгд Бурханы хаанчлалын ирэлтийн талаарх нэг л ижил түүхийг өгүүлдэг боловч тус бүр үүнийг өөр өөрийн замаар харуулдаг. Бид энэ ялгаатай байдлуудыг хоёр үндсэн аргаар судлах болно. Нэгдүгээрт, бид Сайнмэдээний түүхүүд нь хооронд нь яв цав нийцэхэд тулгардаг тодорхой бэрхшээлийг авч үзэх болно. Хоёрдугаарт, бид Сайнмэдээний ном бүрийн тодотгон онцолж буй зүйлсийг авч үзэх болно. Ингээд тэдгээрийг яв цав нийцэхэд тулгардаг тодорхой бэрхшээлүүдийг эхлээд харцгаая.

ТОДОРХОЙ БЭРХШЭЭЛҮҮД

Биднийг Сайнмэдээний номуудыг уншихад тэдний ижил төстэй байдал нь бидэнд гайхалтай сэтгэгдэл төрүүлдэг. Гэвч Сайнмэдээний түүхүүд нь хэд хэдэн ялгаатай зүйлсийг ч өгүүлж буй харагддаг. Мэдээжийн хэрэг, эдгээр ялгаануудын ихэнх нь маш бага тул эдгээрийг ноцтой зөрчилдөөн гэж нэрлэх боломжгүй. Хэдий цөөн ч энэ нь зарим уншигчдад ойлгоход бэрхшээл авчирдаг. Тийм учраас эдгээрээс цөөн хэдэн чухал бэрхшээлүүдийг авч үзэх шаардлагатай болдог.

Он цагийн дараалал

Хамгийн нийтлэг ялгаанууд нь он цагийн дараалал буюу Сайнмэдээний номуудын үйл явдал өрнөсөн цаг хугацааных нь дэс дараалалтай холбоотой байдаг.

Намтар хүүрнэлийн хувьд Сайнмэдээний ном бүр нь он цагийн нэг ижил

үндсэн дараалалтай. Тэд бүгд Есүсийн төрөлтөөр эхэлж, дараа нь Түүний үхэл, тэгээд эцэст нь амиллынх нь тухай өгүүлдэг. Гэвч тэд Есүсийн амьдралд тохиолдсон бусад үйл явдлуудыг ихэвчлэн өөр өөр дарааллаар жагсаасан байдаг. Сайнмэдээний номууд өөрсдийн чухал гэж үзсэний дагуу үйл явдлуудыг бүлэглэдэг нь нэгдүгээр зууны хүмүүсийн хувьд асуудалгүй хүлээн зөвшөөрөгдөх боловч орчин үеийн бидний хүлээлтэд нийцэхгүй байж болох юм. Он цагийн дарааллыг ягштал чанд баримтлахын оронд Сайнмэдээний Номууд нь заримдаа сэдэв эсвэл газарзүйн байрлалын дагуу бүлгүүдээ эрэмбэлдэг. Жишээлбэл, Марк 6:1-6 дээр Есүс төрөлх хотдоо хүлээн зөвшөөрөгдөөгүй түүхийг өгүүлсэн. Гэвч Лук энэ түүхийг өөрийн хүүрнэлдээ илүү эрт буюу Лук 4:14-30-р эшлэлд оруулснаараа Есүсийн олон нийтийн үйлчлэлийн анхны түүх гэж харуулсан. Лукийн Сайнмэдээ нь уг түүхийг Маркийнхаас илүү чухалчилсан байдаг. Мөн энэ нь хүлээн зөвшөөрөгдөөгүй гэсэн сэдвийг онцлохын тулд уг түүхийн илүү урт хувилбарыг өгүүлдэг.

Сайнмэдээний номын бичээчид нь Есүсийн үйлчлэлийг цаг хугацааны дарааллаар яс тодорхойлж дурдахаасаа илүүтэй Түүний сургаал ба үйл хэрэг дэх хаанчлалын ирэлтийг тодорхой илэрхийлэхийг зорьсон байдаг.

Хасалт

Дараагийн нэг ялгаатай зүйл нь гэвэл нэг эсвэл хэд хэдэн Сайнмэдээний номуудад зарим хэсгүүд нь байдаггүй явдал юм. Жишээлбэл, Иохан Сайнмэдээнийхээ номонд Эзэний зоогийн зааврын талаар дурдаагүй. Энэ мэт хассан зүйлсийг олон янзаар тайлбарлаж болно. Эдгээр нь бичээчдийн онцолж буй өөр өөр зорилготой холбоотой байж болдог. Эсвэл хожим нь Сайнмэдээгээ бичсэн бичээчид нь өмнөх Сайнмэдээний номуудад гарч буй зүйлсийг давтах шаардлагагүй гэж үзсэний үр дагавар ч байж болно. Ямартай ч ийм хасалтууд нь Сайнмэдээний номын бичээчдийн хоорондын санал зөрөлдөөн, зөрчилдөөнийг илэрхийлдэггүй.

Хэд хэдэн хүн суугаад хоорондоо ярилцсан гээд бодоод үзье л дээ. Ярьж буй хүн бүр бусдын аль хэдийн хэлсэн бүхнийг давтах шаардлагагүй гэж үздэг шүү дээ. Үүний оронд хүн бүр өөрийн харж буй өнцөг, магадгүй зарим нарийн ширийн шинэ зүйлсийг, эсвэл өөр өөр онцлогийг нэмэхэд анхаарлаа төвлөрүүлдэг.

Бичвэрт энэ талаар тодорхой хэлсэн нь бий. Жишээлбэл, 2Шастир 9:29 дээр шастирч бусад бичээчдийн аль хэдийн тэмдэглэсэн нарийн ширийн зүйлсийг хассан гэдгээ тодорхой хэлсэн. Энэ нь 2Шастир болон 1, 2Хаадын номуудад дор хаяж гурван удаа дурдагддаг. Тийм учраас нэг Сайнмэдээний бичээч өөр нэгнийхээ аль хэдийн дурдсан чухал зүйлсийг хасахад гайхах зүйлгүй юм.

Өөр өөр үйл явдлууд

Гурав дахь нийтлэг бэрхшээл нь Есүсийн үйлчлэлд тохиолдсон янз бүрийн үйл явдлуудын ижил төстэй байдлаас үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, заримдаа хоёр Сайнмэдээний ном нэг үйл явдлыг өөр өөр замаар дүрсэлсэн мэт боловч үнэндээ төстэй мэт хоёр өөр үйл явдлыг дүрсэлсэн байж болдог.

Есүс хэрэн явж номлодог байсныг санах нь чухал. Энэ нь нэг газраас нөгөө

рүү шилжин явж байсан гэсэн үг. Тэрээр адил төрлийн гайхамшгуудыг өөр өөр газар үйлдэж, сохор, доголлон олон хүнийг мөн эдгээжээ. Мэдээжийн хэрэг Есүс ижил төстэй олон асуулт, сорилтуудад дахин дахин хариулсан.

Үүнээс гадна хүмүүс өөр өөр тохиолдлуудад Есүст ижил төстэй байдлаар хариулж байлаа. Лук 7:36-50, Марк 14:3-9 зэрэг эшлэлүүдэд буй Есүсийг тосолсон талаарх түүхийг авч үзье л дээ. Лук номд Есүс фарисай хүний гэрт байдаг бол Марк дээр уяман өвчтэй Симоны гэрт байдаг. Эдгээр нь нэг үйл явдлын талаарх хоёр өөр зөрчилдөөнтэй мэдээлэл огт биш. Харин эдгээр нь хоёр ялгаатай үйл явдлын талаарх тэмдэглэл юм.

Өөр өөр үг хэллэгүүд

Дөрөв дэх төрлийн тодорхой бэрхшээл бол ижил агуулгатай ч ялгаатай үг хэллэгтэй байдаг явдал юм.

Үүнд бидний хамгийн сайн мэдэх жишээ гэвэл Матай 5:1–7:29-р хэсэг дэх Есүсийн Уулын сургаал болон Лук 6:17-49 дээрх үүнтэй төстэй сургаалыг хэлж болно. Матай 5:1 дээр үүнийг уулан дээр болсон гэж өгүүлдэг. Харин Лук 6:17 дээр үүнийг уулын бэлд болсон гэсэн байдаг.

Энэ асуудлыг тайлбарлах дор хаяж гурван арга бий. Нэгдүгээрт, Матай, Лук хоёр хоёулаа ижил цагт, ижил газар айлдсан нэг номлолын тухай ярьж байж болох юм. Галил тэнгисийн баруун өмнөд хэсэг нь уулархаг уулын бэл биш, харин далайн түвшнөөс дээш өргөгдсөн дов толгодтой байдаг. Энэхүү өндөрлөг газар нь харьцангуй тэгш олон жижиг газруудтай байдаг тул нэг л газрыг Матай уулын бэл, Лук тэгш газар гэж нэрлэсэн байх боломжтой. Хоёрдугаарт, энэ нь Есүсийн өөр өөр тохиолдлуудад хэлсэн үгсийг нэг номлолд нэгтгэн оруулсан эмхэтгэл яриа бүтээдэг эртний уламжлалын нэг жишээ байж болох юм. Энэ бол эртний түүхчдийн хэрэглэж байсан арга бөгөөд бүрэн бүтэн, найдвартай байдлын талаар ямар нэг асуудал үүсгэдэггүй аж. Гуравдугаарт, Есүс нэг сургаалаа өөр өөр өдөр, өөр өөр газар буюу нэг нь уулан дээр, нөгөө нь уулын бэлд айлдсан байх боломжтой. Есүсийн үйлчлэлийн хэв маягаас харахад Есүс Өөрийнх нь сургаалыг сонсоогүй хүмүүст сургаал номлолоо давтан зааж байсан харагддаг.

Сайнмэдээний Номуудын ялгаатай байдлуудыг уялдуулж болох эдгээр арга замуудыг ажигласнаар Есүсийн амьдрал, үйлчлэлийн талаарх тэдний нэгдмэл гэрчлэлийг үнэн гэдэгт бид итгэлтэй байж чадна. Тийм ээ, зарим нэг нарийн ширийн зүйлс нь зөрүүтэй мэт харагдах нь бий. Гэхдээ иймэрхүү төрлийн ялгаа болгонд өгөх үндэслэлтэй тайлбарууд ч мөн бий. Есүс өөр өөр тохиолдлуудад нэг л ижил зүйлсийг зааж байсныг бид олж мэдсэнээр Түүний үйлчлэл ба үг яриа нь хоорондоо хэрхэн нийцж, баттай үнэн байдгийг нь харж болдог. Мөн Түүний сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх олон янзын арга замыг олж авч чаддаг.

Бид бичвэрүүд дэх тодорхой бэрхшээлүүдийн талаар авч үзсэнээр Сайнмэдээний дөрвөн номуудын ялгаатай байдлыг судалж эхэлсэн. Тиймээс одоо бид эдгээр номуудын ялгаатай байдлыг үргэлжлүүлэн харахдаа тэдгээрийн онцолж буй ялгаатай зүйлсийг судлахад бэлэн болж байна.

ЯЛГААТАЙ ОНЦЛОГУУД

Сайнмэдээний ном бүрийг Есүсийн амьдрал, үйлчлэлийн талаарх өөр өөрийн харах өнцөг, төвлөрөх зүйлс бүхий өөр өөр онцлогтой хүмүүс бичсэн тул тэдгээрийн хооронд ялгаа их бий. Сайнмэдээний дөрвөн ном бүгд Ариун Сүнсээр онгод оруулагдсан гэдгийг мэддэг учраас алдаа магадгүй бөгөөд хоорондоо зөрчилддөггүй гэдэгт бид итгэлтэй байдаг. Гэхдээ энэ нь хоорондоо ямар ч ялгаагүй гэсэн үг биш юм. Ариун Сүнс эдгээр ялгааг бий болгохдоо хүмүүн бичээчдийн хувийн онцлог, хүсэл сонирхол, үйлчлэлийн нөхцөл байдал зэргийг ашигласан. Тиймээс хэрэв бид Сайнмэдээний номуудаар дамжуулж Ариун Сүнс биднийг ерөөхийг хүссэн бүх арга замаар ерөөгдөхийг хүсэж байвал тэдгээрийг уншихдаа онцлог байдлыг нь харгалзан үзэх шаардлагатай.

Амьдралын олон нөхцөл байдалд янз бүрийн хүмүүс нэг ижил үнэний талаар өөр өөр арга замаар ярьдаг болохыг бид олж хардаг. Нэг үйл явдал хэд хэдэн уялдаа бүхий тайлбартай байдгийг бага насны хүүхдүүд тоглож буйг харсан хүн бүхэн мэддэг шүү дээ. Хүүхэд бүр тоглож буй тоглоомдоо өөрийн гэсэн өнцгөөс харж тоглодог. Тоглоомынхоо талаар чухам юу гэж хэлэхийг нь сонссоноор л бид яг юу болоод байгааг нь ойлгож чаддаг. Тэдний нэгэнд тоглоомынх нь өнгө маш их таалагдсан байж болно. Өөр нэгэнд нь тэдний гаргаж буй дуу чимээг дүрслэх нь сонирхолтой байж магадгүй юм. Өөр нэг нь хөөцөлдөн хөгжилдөх нь сайхан байлаа гэх байх. Эдгээр өөр өөр өнцөг нь хоорондоо ер зөрчилдөхгүй. Гэхдээ хүүхэд бүр тоглоомын зарим хэсгийг илүү сонирхолтой гэж үздэг болохыг харуулж байна.

Үүний адилаар бичээчдийн өөрсдийнх нь үзэл хараа, хүсэл сонирхол нь Сайнмэдээний түүхэнд тусгагдсан байдаг гэсэн үг. Яг адилхан харагдах хоёр түүх гэж байхгүй. Шинэ Гэрээний бүх Сайнмэдээний түүхүүд нэг л ижил Есүсийн тухай өгүүлдэг ч Түүний тухай олон янзаар ярьж, үйлчлэлийнх нь өөр өөр талыг онцлон тэмдэглэдэг.

Бидэнд Сайнмэдээний дөрвөн ном байгаа ч нэг л Есүс бий. Тэгэхлээр бид үүнийг яаж ойлгох вэ? Юуны өмнө, үүнээс бид Есүс бол нэг хөрөг зурагт багтахгааргүй дэндүү бүрэн цогц түүхэн хүн гэдгийг хүлээн зөвшөөрсөн эртний Христитгэгчдийн ухаалаг санааг олж харна. Сайнмэдээний номууд бол яг хөрөг зурагтай адил. Тиймээс каноны Сайнмэдээний номуудаас Есүсийн тухай олж мэдэх боломжтой байдаг. Гэвч үүнтэй зэрэгцэн эдгээрт Есүстэй холбоотой үйл явдлуудыг янз бүрийн өнцгөөс авч үздэг. Жишээ дурдъя л даа. Иоханы Сайнмэдээний номд сургаалт зүйрлэл эсвэл муу сүнсийг зайлуулах явдал үндсэндээ гардаггүй. Харин Маркийн Сайнмэдээнд Есүс сургаалт зүйрлэлүүдийг айлдсан байдгаараа онцлог. Номын эхэн хэсэгт муу сүнсийг зайлуулсан гайхамшгууд элбэг харагддаг. Хэдий эдгээр нь өөр өөр дүр зураг хэдий ч нэг л ижил Есүсийг илчлэн харуулдаг. Мөн номын бичээч бүр Есүсийн тухай бага зэрэг ялгаатай үзэл хараатай байсан. Энэ нь тэдний зарим нь Түүнийг Христ гэж боддог, зарим нь тэгж боддоггүй гэсэн утгатай биш. Харин Есүс бол еврейн амлагдсан Мессиа төдийгүй хүн төрөлхтний Аврагч


байсан гэдгийг хэрхэн илчилж буйгаараа онцлогтой байсан гэсэн үг. Тиймээс тэд эрх чөлөөтэйгөөр буюу Ариун Сүнсний онгод оруулалт дор чөлөөтэйгөөр бичсэн. Тиймээс тэд Есүсийн үйлчлэлийн өөр өөр талууд, өөр өөр хэсгүүдийг онцлох, асуултаа ялгаатай байдлаар тавьж, түүндээ хариулах боломжтой байсан юм.

- Доктор Бен Уидерингтон III

Сайнмэдээний номуудад маш олон ялгаатай онцлогууд болон сэдвүүд бий. Гэвч энэхүү танилцуулга хичээлээр бид “Есүс гэж хэн бэ?”, “бид Есүсийг хэрхэн дагах вэ?” гэсэн хоёр асуултад Сайнмэдээний ном бүр хэрхэн хариулдаг талаар авч үзнэ. Эдгээр чухал асуултуудад Матай хэрхэн хариулж байгааг эхлээд харцгаая.

Матай номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?

Сайнмэдээний номын бичээчдээс Есүс бол Хуучин Гэрээнд зөгнөсөн Израилын хаан Мессиа мөн гэдгийг илэрхийлэхэд хамгийн их анхаарсан хүн бол Матай юм.



Энэхүү номд Есүсийн хаанчлалын тухай дурдсан хэсгүүдийг товчхон харцгаая. Матай 2:2 дээр мэргэд “Саяхан мэндэлсэн, иудейчүүдийн Хаан” хаана байна? гэж асуусан. Мөн 7:21-23-р эшлэлд Есүс Эзэний хувьд Өөрийг нь “Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй гэж хэлсэн. Мөн 20:20-28-р эшлэлд элч Иаков, Иохан нарын эх Есүсээс хөвгүүдийг нь хаанчлалдаа баруун зүүн талдаа суулгахыг хүссэн байдаг. Түүнчлэн 25:31-46 хэсэгт Есүс эцсийн өдөр Хааны ёсоор шүүх талаар сургаалт зүйрлэл айлдсан. Тэгээд мөн 27:37-р эшлэлд Ромын цэргүүд Есүсийн загалмайн дээд хэсэгт “Энэ бол иудейчүүдийн Хаан Есүс” гэсэн тэмдэг тавьж доромжилсныг Матай тэмдэглэжээ.

Бурханы Мессиа хаан нь Бурханы Мессиагийн хаанчлалыг дэлхийд авчирна гэж хүмүүс хүлээж байлаа. Тэрээр Израилыг цөллөгөөс мөн дайснуудаас нь чөлөөлөх болно. Тэрээр зөв шударгаар захирч, энх тайван, хөгжил цэцэглэлтийг тогтооно. Есүс энэ бүхнийг гүйцэлдүүлсэн. Гэвч Тэрээр иудейчүүдийн хүсэн хүлээж байснаар нь үйлдээгүй юм. Энэ талаар Матай 5:17 дээрх Есүсийн үгсийг сонсоцгооё. Энд:

“Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин биелүүлэхийн тулд Би ирсэн юм” гэжээ (Матай 5:17).

Есүс Өөрийнх нь үйлчлэлийг харсан олон олон иудейчүүд Өөрийг нь Бурханы хуулийг хэрэгсэхгүй болгож, Хуучин Гэрээний амлалтуудыг биелүүлэхгүй байна

гэж бодохыг нь мэдэж байлаа. Тийм ч учраас хэдийгээр ингэж харагдахгүй байсан ч гэсэн Тэрээр хууль болоод эш үзүүлэгчдийн хэлснийг биелүүлж байгаа гэдгээ онцлон тодруулсан.

Матай зөвхөн энэ хэсэгт төдийгүй үе үе Хуучин Гэрээний Бичвэрийн нэг эсвэл хэд хэдэн амлалтуудыг Есүс биелүүлснээрээ Өөрийгөө үнэхээр Израилын Мессиа хаан гэдгээ харуулсан хэмээн өгүүлжээ.

Тэгвэл Матайн хэлснээр бид Есүсийг хэрхэн дагах вэ? Есүс Бурханы хуулийг төгс сахисан. Гэвч энэ нь Түүний хийсэн бүх зүйл биш. Тэрээр хуулийн гаднах шаардлагыг биелүүлэх нь хангалтгүй гэж айлдав. Бурхан хаант улсынхаа иргэдээс Өөрийг нь чин сэтгэлээсээ дуулгавартай дагахыг үргэлж шаарддаг. Сайнмэдээний сайн сайхан мэдээ нь чухам Бурханы ард түмэнд уучлал, авралыг авчирч, дуулгавартай, цоо шинэ зүрхийг бидэнд өгдөг тэрхүү хаанчлал ирчхээд байгаа талаарх мэдээ юм. Тэгээд бидний өөрчлөгдсөн шинэ зүрх нь бидэнд Есүсийг хайр, талархал, баяр хөөртэйгөөр дуулгавартай дагах хүч, урам зоригийг өгдөг.

Бид Бурханд бүх зүрхээрээ дуулгавартай байх тухай ярих үед энэхүү зүрх гэдэг нь үнэхээр бүхнийг хамарсан үг хэллэг байдаг. Би хүмүүст үүнийг толгойноос зүрхэнд, зүрхнээс гар хүртлээ гэж заадаг. Энэ бол бид Түүнд хэрхэн дуулгавартай байх, Түүнийг хэрхэн хайрлах хэрэгтэйг харуулж байгаа юм. Толгой бол бодол санаа буюу оюун ухааны талбар бөгөөд бид Бурханыг бүх оюун ухаанаараа хайрлах ёстой. Бид Бурханыг бүх хүсэл зоригоороо хайрлах ёстой. Тэгээд бид Бурханыг бүх гар, хөлөөрөө ч хайрлах ёстой. Тиймээс зүрх гэдэг нь цээжин доторх цохилж байгаа ямар нэг юмыг л хэлдэггүй. Энэ бол бүхнийг хамруулсан үг хэллэг юм шүү дээ. Тэгэхээр бид гаднах байдлаараа л Бурханыг хайрладаг уу? Тийм ээ, бид үнэхээр тэгдэг. Мөн бид Бурханыг бас өөрсдийн хүсэл зоригоороо ч хайрладаг. Бид Бурханыг байгаа бүхнээрээ хайрладаг. Энэхүү "зүрх" гэдэг нь байгаа бүхнийг маань хэлж байгаа гэдэгт би итгэдэг.

- Доктор Мэтт Фридеман

Ингээд Матайн Сайнмэдээ нь бидний хоёр асуултад хэрхэн хариулдаг болохыг бид олж мэдлээ. Одоо харин Марк юу гэж хэлснийг харцгаая.

Марк номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?


Нэгдүгээрт, Маркийнхаар Есүс гэж хэн бэ? Марк номынхоо туршид Есүс бол Бурханы ард түмний дайснуудыг ялсан, Бурханы зовлонт Хүү гэдгийг онцолсон байдаг. Бузар муугийн хүчний дээгүүрх Өөрийн эрх мэдлээ харуулж буй Есүсийн гайхамшгуудын талаар Марк тэмдэглэн үлдээсэн. Хэдийгээр Марк нь Матай, Лук хоёрын Сайнмэдээнээс хамаагүй богинохон ч гэсэн илүү олон буюу нийт арван

найман гайхамшигийг дурдсан.

Маркын Сайнмэдээний эхэн үеэс л Есүс бол ялагч хийгээд зовлон эдлэгч Бурханы Хүү байсныг бид олж хардаг. Эхний бүлгээсээ л Баптисм хүртээгч Иохан Есүсийн ирэлтийг эш үзүүлж, дараа нь Есүс нийтэд хандсан үйлчлэлээ эхлүүлж буй талаар өгүүлдэг. Тэрээр баптисм хүртэж, цөлд соригдож, анхны дагалдагчдаа дуудаж, муу сүнснүүдийг хөөж, олон хүний янз бүрийн өвчнийг эдгээсэн байдаг. Энэхүү адал явдал дүүрэн, гал гарсан гэмээр түүхийг өнгөцхөн уншсан ч Есүс Бурханы хаанчлалын дайснуудыг эрх мэдэлтэйгээр ялан дийлж байгааг олж харна. Нарийвчлан уншвал Есүсийг үйлчлэлийнхээ эхэн үеэс л зовж буй Бурханы Хүү гэсэн байдлаар Марк дүрсэлсэн болохыг бас харна.

Жишээлбэл, Марк 1:12-13-р эшлэл дэх Есүсийн баптисм хүртсэний дараах түүхийг харцгаая. Энд:

“Тэр даруй Сүнс Есүсийг цөл рүү гаргав. Есүс Сатанд сориулан цөлд дөч хоног байлаа. Тэнд Тэр зэрлэг амьтдын дунд байсан бөгөөд тэнгэрэлч нар Түүнд үйлчилж байв” гэжээ (Марк 1:12-13).



Есүсийн нийтэд хандсан үйлчлэлийнх нь эхний мөчөөс л Сатаны дайралт ирсэн байдаг. Марк номд Есүсийг зовж буй зарц гэсэн энэхүү зураглал нь Түүний эсэргүүцэл, хавчлагыг тэсвэрлэж байгаа түүхээр улам л тодорсоор байдаг.

Тэгэхлээр бид зовлон эдэлж буй ялагч Есүсийг хэрхэн дагах ёстой талаар Марк юу гэсэн бэ? Нэг талаас Маркийн Сайнмэдээ нь Христитгэлийн амьдралыг гоё сайхан, амар хялбар гэж дүрсэлсэнгүй. Тэрээр дагалдагч байх нь зовлон эдлээд зогсохгүй унаж бүдэрч, бүтэлгүйтэж байдаг хүнд хэцүү үйл явц хэмээн тодорхойлсон. Үнэн хэрэгтээ Маркийн Сайнмэдээ нь Есүсийн дагалдагчид Есүсийг олон удаа ойлголгүй, итгэлгүй хандсаныг харуулдгаараа онцлог байдаг. Марк 4:40 дээр Есүс дагалдагчдад нь ер итгэл байгаа эсэхийг гайхаж байв. Мөн 6:52 дээр дагалдагчдын “зүрх хатуурсан” тухай, 7:18 дээр дагалдагчид Өөрийнх нь сургаалыг ойлгоогүй учир тэднийг Есүс "ухваргүй" гэж зэмлэсэн тухай өгүүлдэг. Түүнчлэн 9:18-р эшлэлд дагалдагчид нь муу ёрын сүнснийг хөөж чадаагүй тухай, мөн 9:38-41-р эшлэлд дагалдагчид нь Есүсийн нэрээр чөтгөрийг зайлуулах гэсэн хүнийг танихгүй гэсэн шалтгаанаар хориглосон тухай ч бий. Мэдээж 14-р бүлгээс харвал нэг дагалдагч нь эрх баригчдын талд урваж, нэг нь Есүсийг танихгүй хэмээн үгүйсгэж, бусад нь Түүнийг орхин зугтсан болохыг бид мэддэг шүү дээ.

Маркийн Сайнмэдээний энэхүү онцлог нь Есүсийг дагах талаар бидэнд дор хаяж хоёр зүйлийг заадаг. Нэгдүгээрт, дагалдагч нар шиг бид Есүсийг үргэлж ойлгоод байдаггүй. Үнэндээ бид Библи дэх олон зүйлсийг буруугаар ойлгочихсон явж байдаг. Тиймээс бид өөрсдөд маань сурах зүйл их байгааг хүлээн зөвшөөрч, даруу байх хэрэгтэй. Үүний нэг илэрхийлэл болгож хэдий Бурханы үг бидэнд гайхмаар заримдаа бүр буруу мэт санагдаж байсан ч үнэн гэдгийг мэдэж, Библийн сургаалыг итгэлээрээ хүлээн авах хэрэгтэй.

Хоёрдугаарт, Христитгэгчдийн хувьд зовлон, бэрхшээлээс зугтах аргагүй юм. Есүсийг дагахаас биднийг эргүүлж чадах олон аюул, олон уруу таталт бий. Марк 8:34-35 дээр Есүс юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

“Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа үүрч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө, сайнмэдээний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна” гэжээ (Марк 8:34-35).

Есүсийг дагах зориулалтдаа үнэнч байх хэрэгтэй гэж Есүс заасан. Уруу таталт, сүнслэг дайралтуудын эсрэг зогсохын тулд Есүсийн зовж байсан шиг бид зовоход бэлэн байх хэрэгтэй. Гэхдээ энэ хэсэгт өөр нэг зүйл байгааг анзаараарай. Энэ нь Есүс бол зөвхөн *зовж буй* Бурханы Хүү байгаад зогсохгүй Тэр бас Бурханы *ялагч* Хүү мөн. Үнэн хэрэгтээ Тэрээр зовж шаналсан үхлээрээ ялалт байгуулсан. Хэрэв бид хаанчлалын төлөө зовж, Түүнийг үнэнчээр дагавал мөнх амиар шагнагдах болно.

Зовлон нь юу үнэхээр чухал болохыг ухамсарлаж авахад биднийг төвлөрүүлэх үр нөлөөтэй. Учир нь зовлон шаналал нь бүх зүйл ингээд дуусахгүй гэдгийг бидэнд ойлгуулдаг. Би ямар нэг илүү чухал зүйлийн төлөө амьдарч байгаа бөгөөд эдгээр зовлонгийн дунд ч Бурханд итгэсэн хэвээр байдаг. Учир нь Христ дотор надад байгаа зүйл нь миний тайтгарлаас, аюулгүй байдлаас, аз жаргал ба санаа зовдог зүйлсээс минь хавь илүү агуу гэдгийг би мэддэг.


- Доктор Жон Э.Маккинли

Есүс зовж буй зарц болон ирсэн. Мөн Христийг дагадаг хэн бүхэн амьдралдаа ихээхэн зовлон зүдүүрийг үүрэх хэрэгтэй болдог. Энэ нь Есүсийн хэн болохтой маш их холбоотой бөгөөд зовлонгоор дүүрэн энэ ертөнцөд бид ирэхдээ Христийн үйлчлэлийн нэг хэсэг байхын тулд өөрсдийн амьдралдаа зовлон зүдүүрийн орон зайг зөвшөөрөх ёстой болдог. Зөвхөн өөрсдийнхөө зовлонг биш, харин бусад хүмүүсийн зовлон буюу гашуудаж байгаа хүмүүстэй бид хамт гашуудаж, тэдний зовлонг хамтдаа үүрч, нэг хэсэг нь байж тийнхүү үйлчлэх болдог. Тэгээд бид зовлонгоор дүүрэн энэ ертөнцөд үйлчлэхээр ханцуй шамлан орох үед, энэ нь бидний Христийг дагах амьдралд маань Бурханы биднээс хүсдэг үйлчлэлийн гол арга замуудын нэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ үед л бид Бурханы зүрх сэтгэлийг ойлгож эхэлдэг. Тэгээд Бурхан биднийг цэвэршүүлдэг. Энэ зовлон нь зан чанарыг төрүүлж, найдварыг, бас тэсвэр тэвчээрийг бий болгодог. Иймээс Бурхан өөр ямар ч арга замаар биш, зовлон дунд илүү ч үгүй, дутуу ч үгүй ажиллаж, бидний амьдралыг цэвэрлэх арга зам болгож буйг бид харах боломжтой.

- Доктор К.Эрик Тоеннес

Матай, Марк хоёрын талаар үзсэн зүйлсээ санаж байгаарай. Харин одоо Есүс болон Түүний дагалдагчдын талаарх бидний асуултуудад Лук хэрхэн хариулсныг авч үзье.

Лук номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?



Лукийн Сайнмэдээ нь “Есүс гэж хэн бэ?” гэсэн асуултад Тэр бол дэлхий ертөнцийн энэрэнгүй Аврагч гэж тунхаглан хариулдаг. Есүс баян ядуу хүмүүст, шашны удирдагчдад болон нийгмийн гадуурхагдсан хүмүүст ялгалгүйгээр Бурханы авралыг авчирсан. Есүсийн энэхүү сайхан мэдээ нь хүн бүрд, тэр байтугай үл анзаарагдам, жигшигдсэн хүмүүст ч зориулагджээ. Лук үүнийг олон янзаар онцолсон. Олон эрчүүд эмэгтэйчүүдийг дорд үздэг байсан үед Есүс Мариа, Марта гэх эгч дүүстэй түн хүндэтгэлтэй харьцсан байдаг. Эмэгтэйчүүд, өвчтэй, тахир дутуу хүмүүс, тэр ч байтугай иудей бус хүмүүс хүртэл магтуулах зохистой, даган дуурайх ёстой хүмүүс хэмээн Лук Өөрийн сургаалт зүйрлэл, хүүрнэлдээ тэмдэглэн бичжээ. Сүмд хадгалсан жаахан мөнгөө өргөл болгон бүгдийг өргөсөн бэлэвсэн эмэгтэйг Есүс магтсан. Гадуурхагдсан татвар хураагч Закхай нь Есүсийн сургаалд хэрхэн хариу үзүүлснийг бүх уншигчдад үлгэр дууриал болгон дурдсан байдаг. Нийгэмд хүлээн зөвшөөрөгддөггүй эсвэл үл тоомсорлогддог хүмүүсийн төлөөх Есүсийн анхаарал халамжийг Лук байн байн онцлон өгүүлдэг. Жишээ болгон Лук 7:12-16-р эшлэлд буй түүхийг сонсоцгооё. Энд:

“Түүнийг хотын хаалганд ойртон ирэх үед, харагтун, хүмүүс нэгэн үхсэн хүнийг аваад гарч байв. Тэр нь бэлэвсэн эмэгтэйн ганц хүү байсан... Эзэн түүнийг хараад ихэд өрөвдөн түүнд "Бүү уйл" гэв. Тэр очоод авсанд гараа хүргэтэл өргөөд явж байсан хүмүүс зогслоо. Тэгээд Есүс —Би чамд хэлж байна. Залуу минь, бос! гэхэд үхсэн хүн босоод ярьж эхлэв. Ингэж Есүс түүнийг эхэд нь эргүүлэн өгөв. Тэд бүгдээрээ айдаст автаж, Бурханыг алдаршуулж Бидний дунд агуу эш үзүүлэгч гарч ирлээ гэгцгээж, Бурхан ард түмэн дээрээ ирлээ хэмээж байлаа” гэжээ (Лук 7:12-16).

Нэгдүгээр зууны Ромын ертөнцөд хүүгээ алдсан бэлэвсэн эмэгтэй өөрийгөө тэжээх боломж хомс, ажил олдох хэцүү байв. Есүсийн энэ эмэгтэйг өрөвдөх сэтгэлийг онцлон тэмдэглэснээр Эзэний аврагчийн ажил нь ядуу, тусламж хэрэгтэй хүмүүст ч зориулагдсан гэдгийг тухайлан мэдүүлжээ. Энэ түүхийн төгсгөлд буй хүмүүсийн тайлбарласнаар гачигдалтай, хүчгүй хүмүүст Есүс ийнхүү үйлчилсэн нь Бурхан ард түмэндээ туслахаар ирсний баталгаа гэв.

Тэгвэл Лукийн Сайнмэдээ "бид Есүсийг хэрхэн дагах вэ?" гэх хоёр дахь асуултад яаж хариулдаг вэ? Ядуу хүмүүсийн төлөө Лукийн санаа тавилт шиг бидний

хийж чадах нэг зүйл бол бусдыг өрөвдөх сэтгэлтэй байх явдал юм. Бид ядууст санаа тавьж, тэдний хэрэгцээг хангахыг эрэлхийлэх ёстой. Бид эд хөрөнгө, хоол хүнс, мөнгө, цаг заваа зориулахад бэлэн байх ёстой. Үнэн хэрэгтээ тусламж хэрэгтэй хүмүүсийн залбирлын хариуд Бурхан өгөөмөр Христитгэгчдийг илгээдэг. Лук 12:33 дээр Есүс энэ тухай өгүүлдэг. Тэрээр энд:

“Өмч хөрөнгөө худалдаад өглөг өг. Хэзээ ч хуучрахгүй уутыг өөрсдөдөө зэх, шавхагдашгүй баялгийг тэнгэрт хураа. Тэнд хулгайч ойртохгүй, хивэн хорхой сүйтгэхгүй” гэжээ (Лук 12:33).

Бид Есүсийг үнэнчээр дагаж, Түүний ард түмэнд санаа тавих юм бол Тэр биднийг мөнхийн өвөөр шагнадаг.

Есүсийг дагах өөр нэг арга бол Бурхан бидний хэрэгцээг бас хангах болно гэдэгт итгэлтэй байх явдал юм.

Лук 12:22-31-р хэсэгт Есүс юу гэснийг хамтдаа харцгаая. Энд:

“Юу идэж, юу уух билээ гэж амийнхаа төлөө бүү санаа зов. Мөн юу өмсөх билээ гэж биеийнхээ төлөө ч бүү санаа зов... Юу идэх, юу уух билээ гэж та нар бүү хай, бүү санаа зов... Гагцхүү Түүний хаанчлалыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” гэжээ (Лук 12:22-31).

Бурханы хаанчлалын гишүүдийн хувьд бид агуу хаан Есүс Христ бидний төлөө санаа тавьж, хэрэгцээг маань хангана гэдэгт итгэлтэй байж болно.

Мөн Аврагчид итгэхийг ийнхүү онцолсон нь Лукийн Сайнмэдээний өөр хоёр сэдэв болох амар амгалан ба баяр баясгалан зэрэгтэй нягт холбоотой байдаг. Жишээлбэл, Лукийн Сайнмэдээний 2:10-14-р эшлэл дээрээс бид тэнгэрэлчийн мэдэгдлийг олж уншдаг. Энд:

“би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайхан мэдээг та нарт авчирлаа ... Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, Доор газарт амар тайван нь Түүний тааллыг олсон хүмүүст байх болтугай” гэжээ (Лук 2:10-14).

Лук Сайнмэдээгээ хэрхэн эхлүүлсэн шигээ хорин хоёр бүлгийн дараа ч мөн яг тийнхүү дуусгасан байдаг. Түүхийн төгсгөлд дагалдагчид Есүсийг дагаж, 2-р бүлэгт тэнгэрэлч нарын эш үзүүлсэн тэрхүү баяр хөөрөөр дүүрэн байсныг өгүүлдэг.

Иохан 20-р бүлэгт Есүс гурвантаа “Амар амгалан та нарт байх болтугай” гэсэн байдаг. Тэрээр зүгээр л сайн уу гэж хэлээгүй байх гэж би боддог. Тэрээр үүнийг бодит байдлын ганхашгүй суурь юм гэдэг санаагаар хэлсэн. Хэдий чи зовлон шаналлыг амсаж, хайртай хүмүүсээ алдан, Намайг хэзээ эргэж ирэхийг ч мэдэхгүй байтал Ромын дарангуйлал дор хавчигдан, нөхцөл байдал улам л дордох боловч Би та нартай хамт байж тэрхүү ганхашгүй суурь

болсон амар амгаланг авчрах болно гэдгийг мэдээсэй хэмээн хүссэн. Би чиний баяр баясгалан. Тиймээс юу ч тохиолдсон, гаднах амьдралд чинь юу ч тохиолдсон, дотоод амьдралд чинь бас юу ч тохиолдсон, хэрэв чи Намайг мэддэг бол жинхэнэ ганхашгүй амар амгалан нь чамд байх болно. Библийн үг нь "шалом" бөгөөд энэхүү Бурханы зөвт захиргаа ба засаглал нь чамд юу ч тохиолдсон байсаар байна. Тэгээд би баяр хөөрийг авчирдаг. Би энд зөвхөн та нарыг тайвшруулах гэж бус жинхэнэ баяр баясгаланг, сэтгэл хөдлөлөөс хавь илүү баяр баясгаланг авчрахаар та бүгдтэй хамт байна. Баяр баясгалан гэдэг нь Би бүх ертөнцийг удирдаж байгаа бөгөөд Миний зөвшөөрөлгүйгээр юу ч чамд тохиолдохгүй гэсэн үг юм хэмээн Есүс хэлж байна. Паул Сүнсний үр жимсний тухай ярихдаа ийнхүү хэлсэнд нь би үнэхээр дуртай. Ариун Сүнс ирж Христитгэгчдийн амьдралыг дүүргэх үед тэд бүгд хайраар дүүрнэ гэж хэлснийхээ араас баяр хөөрөөр бялхах болно гэж Тэрээр хэлсэн байна шүү дээ. Эдгээр нь хоорондоо салшгүй холбоотой гэж би боддог. Мэдээжийн хэрэг тэр өөр зургаан зүйлсийн тухай ч өгүүлдэг. Харин хамгийн гол зүйл нь энэхүү Бурханы хайр миний зүрхэнд цутгагдан дүүрэх явдал байдаг. Тийнхүү үр дүнд нь бодит байдлын талаарх өөрийн тун сөрөг, гутранги, бүр увайгүй ойлголтоороо бид цаашид амьдрахгүй болдог. Есүс бидэнтэй хамт оршин байхад л бид амар тайван байна. Тэрээр миний амьдралд Өөрийн амиллын хүчийг авчирсан бөгөөд Түүний л дотор надад баяр хөөр, итгэл найдвар бий. Учир нь Есүс дотор ялагдал үгүй. Ямар ч "тусдаа салангид зүйлс" гэж үгүй. Тэр бүгдийг бүрэн бүтэн нэгдмэл болгодог.

- Доктор Билл Ури

Лук 24:52-53 дээрх Лукийн сүүлчийн үгсийг сонсоцгооё. Тэрээр энд:

"Тэд Түүнд мөргөөд үлэмж баяр хөөртэйгөөр Йерусалимд буцан ирж сүмд байнга байж, Бурханыг магтсаар байв" гэжээ (Лук 24:52-53).


Лукийн Сайнмэдээнд Есүсийг дагах гэдэг нь өөрсдийн аврал болон Бурханы бүх ерөөлд баярлаж, Түүн дотор амар амгалан байж, бидний бүх хэрэгцээг Тэрээр хангана гэдэгт итгэхийг, мөн энэхүү ерөөлүүдийг бусдад өгөхийн тулд Түүгээр ашиглагдахад бэлэн байна гэсэн үг юм.

Бид Матай, Марк, Лук нар "Есүс гэж хэн бэ?" мөн "Бид Түүнийг хэрхэн дагах вэ?" гэсэн асуултуудад хэрхэн хариулсан талаар үзлээ. Одоо бид Иохан эдгээр асуултуудад ямар онцлогтойгоор хариулсныг авч үзэхэд бэлэн боллоо.

Иохан номд Есүсийг хэн гэж өгүүлдэг вэ?

Иохан Сайнмэдээндээ Есүсийг авралын мөнхийн төлөвлөгөөг биелүүлдэг

Бурханы Хүү хэмээн дүрсэлсэн байдаг. Иохан Есүсийг Бурханы Хүү гэдгийг онцлохдоо Есүсийн Эцэгтэйгээ харьцах онцгой харилцааны талаар өгүүлсэн. Есүс бол Эцгийнхээ бүрэн төгс илчлэл бөгөөд Өөрт нь итгэлээ тавьсан бүх хүмүүст мөнх амийг өгдөг цорын ганц Нэгэн юм. Тухайлбал, бусад гурван Сайнмэдээний номуудын бичээчид нь номоо Есүсийн төрөлт ба дэлхий дээрх үйлчлэлийн тухай түүхээр эхлүүлсэн байдаг. Харин Иохан Сайнмэдээгээ Бурхан ертөнцийг бүтээхэд Хүү оролцсон хийгээд одоо Эцэг Өөрийн цор ганц Хүүгээрээ илчлэгдэж байна гэх түүхээр эхэлсэн юм.



Энэ гайхамшигт мэдээг дамжуулсан Иоханы өөр нэг арга бол Есүс Өөрийгөө “Би байгаа юм” хэмээн хэлснийг онцолсон явдал юм. Эдгээр тунхаглалууддаа Есүс заримдаа “Ёхова” гэж орчуулагддаг “ИАВЭ” хэмээх Бурханы гэрээний нэрийг битүүгээр хэлсэн. Гэтлэл 3:14-р эшлэлд Бурхан Өөрөө энэхүү “ИАВЭ” гэдэг нэр нь “Би байгаа” гэсэн утгатай болохыг тайлбарласан. Иохан 6:35 дээр Есүс “Амийн талх бол Би байгаа юм” гэж хэлсэн байдаг. Үүнийг бид мөн 8:12 ба 9:5 дээрх “Ертөнцийн гэрэл бол Би байгаа юм” гэснээс олж болно. Мөн 10:7, 9-р эшлэлүүдэд бид “Үүд нь Би байгаа юм” гэснийг олж уншдаг. Түүнчлэн 11:25 дээр “Амилал ба амь бол Би байгаа юм” гэсэн байдаг бол 14:6 дээр “Зам, үнэн, амь бол Би байгаа юм” гэжээ. Мөн 15:1 дээрээс бид “Би бол усан үзмийн жинхэнэ мод” гэснийг олж харна. Ингээд 8:58-р эшлэлд Есүс “Би байгаа юм” гэсэн хамгийн оргил тунхгаа зарлав. Эдгээр тохиолдол бүрд Есүс Өөрийгөө Хуучин Гэрээний ариун Бурханы нэрийг тээгч гэдгээ тунхаглаж, Бурханыг Өөрийн бодгалиар илчилсэн билээ.

Бурханы авралын мөнхийн төлөвлөгөөний гол төв болсон Есүсийн байр суурь нь Иохан 17-р бүлэг дэх Есүсийн тэргүүн тахилчийн залбирлаас онцгой тод харагддаг.

Иохан 17:24 дээр Есүс юу гэж залбирсныг харцгаая. Энд:

“Эцэг минь, Надад өгсөн хүмүүс тань Миний байдаг газарт Надтай хамт байж, сүр жавхланг минь үзээсэй гэж Би хүсэж байна” гэжээ (Иохан 17:24).

Есүс дагалдагчдынхаа авралыг бүтээлээс ч өмнө байсан Хүүгээ гэх Бурхан Эцэгийн хайртай холбосон. Түүний хэлсэн гол санаа нь Эцэгийн Есүсийг хайрлах хайр хальж асгарсан нь бидний аврал болжээ гэв.

Тэгэхээр хэрэв Иохан Есүсийг мөнхийн авралын төлөвлөгөөг гүйцэлдүүлсэн Бурханы Хүү гэж дүрсэлсэн юм бол Иоханы Сайнмэдээ бидний хоёр дахь асуултад хэрхэн хариулдаг вэ? Бид Есүсийг хэрхэн дагах вэ?

Иоханы Сайнмэдээнд бидний Есүсийг дагах гол арга зам бол Бурханы хайрыг хүлээн авч, бие биедээ энэ хайрыг харуулах явдал юм. Олон талаараа үүнийг дагаасай гэсэндээ Есүс энэ загварыг бидэнд өгсөн. Тухайлбал, бид үүнийг Иохан 17:23-26-р эшлэлээс олж хардаг. Есүс энд Эцэгийн Хүүгээ гэх хайрын тухай өгүүлдэг. Есүсийн гүйцэлдүүлсэн авралын мөнхийн төлөвлөгөөний ард Хүүгээ гэсэн

Эцэгийн мөнхийн хайр байсан юм. Тиймээс Иоханы Сайнмэдээнд дагалдагч байна гэдгийг хайраар тодорхойлдог. Иохан 13:34-35-р эшлэлд Есүс дагалдагчдаа ийн хэлсэн:

“Бие биеэ хайрлагтун. Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун. Бие биедээ хайртай байваас үүгээр чинь та нарыг Миний шавь гэдгийг бүгд мэдэх болно” гэжээ (Иохан 13:34-35).

Иоханы хэлснээр бол бид бие биеэ Түүний хайраар хайрласнаар Түүнийг дагадаг.

Ийнхүү дагалдууллыг хайраар эхлүүлж, энэ л хайраар үргэлжлүүлдэг. Биднийг гэсэн Бурханы хайр л бидний дагалдагч байх үндэс болдог. Ийнхүү биднээр дамжин бусад руу урсах Бурханы хайр бол бидний дагалдууллын илэрхийлэл юм. Энэ нь Иохан яагаад Сайнмэдээнийхээ туршид өөрийгөө "хайрладаг дагалдагч" гэж биш, харин "Есүсээр хайрлагдсан дагалдагч" гэж нэрлэснийг ойлгоход бидэнд тусална. Бусдыг хайрлах ямар ч чадвар Есүсийн өөрийг нь хайрлах хайрын гүнээс ирдэг гэдгийг Иохан мэдэж байв. Есүсийн дагалдагчид эхлээд хайрлагдаж, дараа нь бие биеэ хайрлахад дуудагдсан.

Сайнмэдээний дөрвөн номын онцлог ялгаанууд нь ямар нэгэн байдлаар хоорондоо нийцэхгүй зөрчилдсөн түүхийг өгүүлж байгаа юм биш үү гэж зарим нь гайхаж болох юм. Гэвч би тийм биш гэж хэлэх байна. Сайнмэдээний дөрвөн номд байгаа бүхэн нь Есүсийн түүхийг өгүүлэх өөр хоорондоо нийцтэй дөрвөн өнцгийг бидэнд харуулдаг. Эдгээр ном нь бүгд гэмт хүмүүсийг нүгэл ба үхлээс аврахын тулд дэлхий дээр Бурханы биежилт болж ирсэн Нэгэний түүхийг өгүүлдгээрээ нэгдмэл нэг санаатай байдаг. Мөн Сайнмэдээний ном бүр Есүсийг өөр өөр өнцгөөс харж, Түүний амьдралын янз бүрийн нарийн ширийн зүйлсийг онцлон тэмдэглэдэг ч тэдгээрийн хэлж буй санаа, харж буй өнцөг нь өөр хоорондоо огтхон ч зөрчилддөггүй, харин ч хоорондоо холбогдон нийцэж байдаг.

- Доктор Стивен Кован

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Сайнмэдээний номуудын талаар үзэж танилцлаа. Эдгээр нь уран зохиолын төрөл жанрын хувьд найдвартай түүхэн хүүрнэл гэдгийг бид олж харсан. Тэднийг Шинэ Гэрээний Бичвэрийн найдаж болох хэсэг гэдгийг бид харах замаар чуулган дахь байр суурийг нь авч үзсэн. Мөн бид тэднийг өөр хооронд нь харьцуулан судалж үзээд, тэдгээр нь хэдий Есүс болон дагалдагч байх тухай өөр өөрийн өнцгөөс дүрсэлсэн ч Бурханы хаанчлалын талаарх нэг л ижил түүхийг өгүүлдэг болохыг олж мэдсэн.

Сайнмэдээний Номуудыг ойлгох нь Христитгэгч хүн бүрийн хувьд онцгой чухал юм. Бид хэзээ ч нүүр нүүрээрээ уулзаж байгаагүй Есүсийн гарт энэ амьдралаа болон ирэх амьдралаа даатган, итгэл найдвараа тавьдаг. Түүний тухай бидний мэддэг бүхий л зүйлсийг бид Түүний Үгээс, онцгойлон Сайнмэдээний Номуудаас олж мэддэг. Энэхүү удиртгал хичээлээс бидний сурсан зүйлс цаашид Сайнмэдээний дөрвөн ном тус бүрийг илүү гүнзгий судлахад биднийг бэлтгэсэн гэдэгт итгэлтэй байна. Тийнхүү бид Сайнмэдээний бичээчдийн мэдээ нь бидний итгэл ба амьдралд хэрхэн нөлөөлж байгааг ойлгох юм.

ХАМТРАГЧИД

Др. Пит Алвинсон (Хөтлөгч) нь FORGE буюу “Толин тусгал дахь Эрэгтэй” гэх хот даяарх эрчүүдийн үйлчлэлийн гүйцэтгэх захирал. Тэрээр мөн Флорида мужийн Винтер Спрингс дэх Виллоу Грик Пресвитериан чуулганы (РСА) үүсгэн байгуулагч бөгөөд 26 жилийн турш Тэргүүн Пастороор үйлчилсэн нэгэн юм. Доктор Алвинсон нь Библи Судлалын магистрын зэргээ Тринити Евангелийн Дивинити сургуульд, Үйлчлэлийн Докторын зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуульд тус тус хамгаалсан. Тэрээр Шинэчлэлийн Теологийн Сургуулийн дэд профессор, Амьдралын Түлхүүр Сүлжээний Удирдах Зөвлөлийн Гишүүн. Тэрээр *Аав шиг, Хүү шиг: Бурханыг аав шигээ мэдэх нь хүмүүсийг хэрхэн өөрчилдөг вэ?* номын зохиогч юм.

Др. Ричард Баукхэм нь Шинэ Гэрээний эрдэмтэн, зохиолч бөгөөд Шотландын Гэгээн Андрей их сургуулийн хүндэт профессор.

Др. Дэвид Р. Бауэр нь Асбери Теологийн Сургуулийн Индактив Библи Судлалын Ральф Валдо Бисон Профессор бөгөөд Библийн Тайллын Сургуулийн хичээлийн эрхлэгч.

Др. Стивен Кован нь Линкольн Мемориал Их Сургуулийн Философи ба Шашны профессор, Итгэлээ өмгөөлөхүйн Эх сурвалж Төвийн ажилтан, Бирмингемийн Теологийн Сургуульд Философи ба Итгэлээ өмгөөлөхүйн дэд профессор

Др. Дан Дориани нь Библийн болон Системт Теологийн профессор бөгөөд, Сент-Луис дахь Ковенант Теологийн Сургуулийн дэд ерөнхийлөгч, мөн Сайнмэдээний Эвслийн Зөвлөлийн гишүүн.

Др. Мэтт Фридеман бол Уэсли Библийн Сургуулийн Дагалдуулал ба Сайнмэдээний профессор.

Пастор Майкл Ж.Глодо бол Флоридагийн Орландо дахь Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Пасторын Теологийн дэд профессор юм.

Др. Жон Э. МакКинли бол Талбот Теологийн Сургуулийн Библи ба Теологи судлалын дэд профессор.

Др. Ионатан Т. Пеннингтон нь Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Судалгааны Доктор Судлалын захирал, Шинэ Гэрээний Тайллын туслах профессор юм.

Доктор Грегори Р. Пэрри нь Гурав дахь Мянгын Үйлчлэлийн Стратегийн Төсөл хариуцсан дэд ерөнхийлөгч, Гурав дахь Мянгын Семинарийн Ерөнхийлөгч. Тэрээр өмнө нь Ковенант Теологийн Сургуульд Шинэ Гэрээний дэд профессор, Хотын Үйлчлэлийн Санаачилгын захирлаар ажиллаж байсан.

Др. Роберт Л. Плуммер бол Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Библи судлалын

Коллин, Эвелин Айкман профессор бөгөөд Грек хэлийг өдөр бүр нэг дусал нэвтрүүлгийн үүсгэн байгуулагч, хөтлөгч.

Др. Дэвид А. Ределингс нь Бетел Сургуулийн Шинэ Гэрээний профессор.

Др. Томас Р. Шрайнер бол Жэймс Буханан Харрисоны Шинэ Гэрээний орчуулгын профессор ба Өмнөд Баптист Теологийн Семинарт Бичвэр ба орчуулгын эрхлэгч

Др. К. Эрик Тоеннес нь Биола Их Сургуулийн Талбот Теологийн Сургуулийн Библи ба Теологи Судлалын профессор, Библи ба Теологи Судлалын теологийн тэнхимийн эрхлэгч.

Др. Стивен Цоукалас нь Гаити дахь Эммау Библийн Сургуулийн Профессор, Итгэлээ өмгөөлөхүй ба Дэлхийн Шашны тэнхимийн эрхлэгч, Вэсли Библийн Сургуулийн багш асан.

Др. Билл Ури 24 жилийн турш Вэсли Библийн Сургуульд Системт ба Түүхэн теологийн профессор байсан бөгөөд одоо Хойд Каролина дахь Элизабет хотын Евангелийн Методист Чуулганы пастораар ажиллаж байна.

Рев. Др. Симон Виберт бол Англи, Виржиниа Воте дахь Христийн Чуулганы туслах пастор бөгөөд Оксфорд, Вайклифе Холл дахь Номлолын Сургуулийн Дэд Ерөнхийлөгч ба Захирал асан.

Др. Петр Уолкер нь Тринити Сургуулийн Библи судлалын профессор, Оксфордын Уиклиф Холлд дэд захирал асан. Одоо Библи судлалын Иерусалим Төвд багш.

Др. Бен III Витерингтон нь Асбери Теологийн Сургуулийн Докторын судалгааны Шинэ Гэрээний Амос номын профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

христос – Христийг илэрхийлдэг грек үг (галиг). Энэ нь “тослогдсон нэгэн” болох “*машиах*” ба “мессиа” гэдэг үгийн Септуагинт дахь хувилбар.

гэрээ – хоёр талуудын эсвэл бүлэг хүмүүсийн, мөн Бурхан ба хүн хоорондын байгуулсан хууль ёсны хэлэлцээр

евангелион - "Сайнмэдээ" гэсэн грек үг (галиг). Шууд утгаараа "сайхан мэдээ"

Еусебий - (МЭ 263-340 он) *Сүмийн түүхийг* бичсэн эртний Христэч түүхч

жанр - Уран зохиолын хэв маяг эсвэл төрөл ангилал

Сайнмэдээ – Шууд утгаараа “сайхан мэдээ” буюу Бурханы хаанчлал Есүсийн биежилт ба үйл хэргээр дамжуулан дэлхий дээр ирсэн бөгөөд Есүсийг Мессиа хэмээн хүлээн авч, Түүнд итгэдэг хүмүүст Бурхан авралыг өгснөөр энэ нь агуу биелэл рүүгээ тэлж байгаа талаарх тунхаглал

Сайнмэдээний Номууд- Матай, Марк, Лук, Иохан нарын бичсэн Шинэ Гэрээний номууд

түүхэн хүүрнэлүүд - Өнгөрсөн үед тохиолдсон үйл явдлуудыг бичсэн түүхүүд

Иренаус - (ойр. МЭ 130-202 он) 2-р зууны бишоп, эртний Христитгэгч зохиолч, *Тэрсүүдийн Эсрэг* номын бичээч, Гностик үзлийг няцааж, Сайнмэдээний дөрвөн номын үнэн зөвийг баталсан нэгэн

Иохан – Зебедеен хүү, Иаковын дүү, арван хоёр элчийн нэг, Иоханы Сайнмэдээний Ном болон 1, 2, 3 Иохан, Илчлэл номын бичээч. Түүнийг "Есүсийн хайртай шавь" гэж нэрлэгдэг.

Иосефус – (МЭ 37- ойр. 100 он) МЭ 1-р зууны еврей түүхч, *Антикютис* номын зохиолч

куриос – "эзэн", "захирагч", "эзэгнэгч" эсвэл "ноён" гэсэн утгатай грек үг (галиг). Шинэ Гэрээн дэх Бурханы нэр

Лук – Гурав дахь Сайнмэдээний ном болон Үйлс номын бичээч, Христитгэгч харь үндэстэн бөгөөд Паулын хамтран зүтгэгчдийн нэг. Түүнийг эмч байсан гэж үздэг

Марк – Иохан Марк гэгддэг; Маркийн Сайнмэдээний номын бичээч, Барнабын үеэл, Паул ба Барнаб хоёрын илгээлтийн анхны аялалд дагалдан явсан нэгэн

Матай – Есүсийн арван хоёр дагалдагчдын нэг, Матайн Сайнмэдээний номын бичээч. Есүс түүнийг дуудах үед тэрээр татвар хураагч байсан ба түүнийг мөн Леви гэдэг

Мессиа – "тослогдсон хүн" гэсэн утгатай еврей үг. Энэ үеэс ирэх үе рүү шилжих шилжилтийг авчрах Давидын удмын агуу хаан. Грек хэлэнд "*Христос*" гэж орчуулдаг.

Ориген - (ойр. МЭ 185 – 254 он) Александрын анхны Христэч теологич. Тэрээр *Анхны Зарчмуудын тухайд* (On First Principles) гэх номдоо Ариун Бичвэр бол Христитгэлийн онол сургаалын эцсийн дээд эрх мэдэл хэмээн хамгаалсан байдаг. Мөн Хуучин Гэрээний янз бүрийн орчуулгын харьцуулсан судалгаа болох Хексаплаг бичсэн нэгэн

Петр – Симон гэгддэг Есүсийн арван хоёр дагалдагчдын нэг, анхны Христийн чуулганы удирдагч, Үйлс 2-р бүлэгт Пентекостын өдөр номлосон нэгэн. Чуулганы түүхчдийн үзэж байгаагаар Марк Сайнмэдээгээ бичихдээ Христийн

амьдралын талаар бичсэн Петрийн түүхүүдэд тулгуурласан гэдэг.

Плутарх - (ойр. МЭ 46-120 он) Грекийн шашингүй үзэлт түүхч, намтар судлаач

Давидын Хүү – Мессиаг хэлдэг нэр. Тэрээр Давидын удмаас гарч, Бурханы ард түмнийг аврах удаан хүлээлгэсэн, зөвт Нэгэн. Шинэ Гэрээнд Есүсийг ийнхүү хэлдэг байсан (ялангуяа Матай номд)

синоптик - "хамтад нь харах" гэсэн утгатай нэр томьёо. Матай, Марк, Лук нарын Сайнмэдээний номуудын ижил төстэй байдлыг тодорхойлоход ашигладаг үг

талмид – “дагалдагч” буюу оюутан эсвэл суралцагч гэсэн утгатай еврей үг (галиг)

Талмуд - МЭ 1-р зуунаас эхлэн 600 орчим жилийг хамарсан Еврейн иргэний болон ёслолын хуулийн талаарх рабби нарын сургаалын цуглуулга

ЯВЭ/ЭЗЭН – "Би бол би байгаа" гэсэн хэллэгээс гаралтай Бурханы еврей нэр бөгөөд ихэвчлэн "ЭЗЭН" гэж орчуулагддаг